



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 4

- Монгол Улсын Их Хурлын тухай Монгол Улсын хууль
- Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай Монгол Улсын хууль
- Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хууль
- Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ,
ШИЙДВЭР, ХУУЛИЙН ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлын Хэвлэл

№ 1997 оны 4-р сар №4 /59/

ГАРЧИГ

1. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|----|--|-----|
| 1. | Монгол Улсын Их Хурлын тухай | 307 |
| 2. | Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай | 322 |
| 3. | Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай | 353 |
| 4. | Хууль хүчингүй болсонд тооцох тухай | 360 |
| 5. | Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай | 361 |

2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | |
|----|--|-----|
| 6. | Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай № 18 | 362 |
| 7. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль тоглон зарлах тухай № 20 | 362 |
| 8. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын хэмжээ тогтоох тухай № 21 | 363 |

3. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

- | | | |
|----|--|-----|
| 9. | Улсын Их Хурлын 1997 оны хаврын чуулганыг нээх, чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай № 49 | 364 |
|----|--|-----|

4. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | |
|-----|--|-----|
| 10. | Д. Балбаярыг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнах тухай № 28 | 366 |
| 11. | Зарлигууд хүчингүй болсонд тооцох тухай № 29 | 366 |
| 12. | Ц. Цэрэндоржид Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол олгох тухай № 31 | 367 |
| 13. | Төрийн хянан шалгах байгууллагын зарим ажилтныг одон, медальгаар шагнах тухай № 32 | 367 |
| 14. | Зарим хүнийг "Атлан гадас" одонгоор шагнах тухай № 33 | 368 |
| 15. | Зарим шүүхийн шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлөх тухай № 34 | 370 |
| 16. | Шүүгчийг томилж туслах тухай № 35 | 371 |

18.	В.Н. Меркуловыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай № 36	371
19.	Г. Мянгаржавыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай № 37	371
20.	Шаравын Гунгаадоржийг эгчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай № 39	372
21.	Юмбуутийн Сандагийг эгчин сайдаар томилж тухай № 40	372
22.	Нинцэгийн Очирбалыг эгчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай № 41	373
23.	Калдырын Сайрааныг эгчин сайдаар томилж тухай № 42	373
24.	Зөвшөөрөл олгох тухай № 43	374

5. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

25.	Албан тушаалын цалин тогтоох, тэрэгчдэд замааруулах тухай № 60	375
26.	Хэлэлцээр батлах тухай № 61	375
27.	Тогтоол хүчингүй болгох тухай № 62	376

6. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

28.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуультай холбогдсон маргааныг хянан хэлэлцсэн тухай № 7	377
29.	Оршоол үзүүлдэх тухай Монгол Улсын хуультай холбогдсон маргааныг хянан хэлэлцсэн тухай № 8	382
30.	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх талаарх маргааныг хянан шийдвэртэсэн тухай № 9	386
31.	Монгол Улсын Ерөнхий сайд М. Энхсайхан Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцсэн тухай № 10	391

7. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

32.	Эрүүгийн хуулийн 216 дугаар зүйлийг тайлбарлах тухай № 244	395
33.	Монгол Улсын Зохиогчийн эрхийн тухай хуулийн зарим зүйл, хэсгийг тайлбарлах тухай № 15	396
34.	Байгаль орчныг хамгаалах хуулийн 16 дугаар зүйлийг тайлбарлах тухай № 30	397

МОНГОЛ УЛСЫН Х У У Л Ъ

1997 оны 2 дугаар
сарын 6-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ Х У У Л Ъ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурлын /цаашид “Улсын Их Хурал” гэх/ бүрэн эрх, түүний зохион байгуулалтын бүтэц, бүрэлдэхүүнтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Улсын Их Хурлын тухай хууль тогтоомж

Улсын Их Хурлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль /цаашид “Үндсэн хууль” гэх/, энэ хууль болон холбогдох бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрээс бүрдэнэ.

3 дугаар зүйл. Улсын Их Хурлын үйл ажиллагааны үндсэн зарчим

Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалах, эрх зүйт төрийг төлөвшүүлэх, монголын ара түмний хүсэл зориг, эрх ашиг, эв нэгдлийг хангах, ардчилал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулан хэрэгжүүлэх зарчимд үндэслэнэ.

4 дүгээр зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

1. Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлд заасан онцгой бүрэн эрх, хуулиар тогтоосон бусад бүрэн эрх эдэлж хэрэгжүүлнэ.

2. Энэ хуульд заасан “Улсын Их Хурлын нийт гишүүн” гэдгийг Үндсэн хуульд заасан ёсоор 76 гэж ойлгох бөгөөд тэдний дөрөвний гурав буюу 57-гоос доошгүйн бүрэн эрх хууль ёсоор хүлээн зөвшөөрсөн нөхцөлд Улсын Их Хурлыг бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүрэлдэхүүнтэйд тооцно.

5 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа

1. Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа 4 жил байна.

2. Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа нь Үндсэн хуулийн хорин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар гишүүд Төрийн сүлдэнд тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болно.

3. Үндсэн хуулийн хорин хоёрдугаар зүйлд заасан онцгой ноцоллийн улмаас ээлжит сонгууль явуулах боломжгүй бол мөнхүү ноцол арилж, шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

4. Улсын Их Хурал Үндсэн хуулийн хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар өөрөө тарах шийдвэр гаргасан бол шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөтөл бүрэн эрхээ хэвээр адална.

6 дугаар зүйл. Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд баримтлах журам

1. Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хороодын хуралдааныг бэлтгэн явуулах, хуралдаанаар тодорхой асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэх, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл хянан хэлэлцэх, санал хураалгах, батлах, Улсын Их Хурал шийдвэр гаргах, түүнийг биелэлтэд хяналт тавих зэргээр Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Улсын Их Хурлын хуралдааны дэгийг баримтална.

2. Улсын Их Хурлын хуралдааны дэгийг хуулиар тогтооно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Улсын Их Хурлын зохион байгуулалтын бүтэц

7 дугаар зүйл. Улсын Их Хурлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр

1. Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, Байнгын болон тэр, дэд хороо, намын бүлэг, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ.

2. Улсын Их Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь чуулган мөн.

3. Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг Үндсэн хуулийн хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар нийт гишүүний дийлэнх олонхи буюу гуравны хоёр нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд тоошно.

Энэхүү ирцийг Улсын Их Хурлын ээлжит, ээлжит бус, онцгой чуулганы нээлтийн хуралдаан, чуулганы өдөр бүрийн хуралдааныг эхлүүлэх, тухайн өдрийн хуралдаанаар шинэ асуудал хэлэлцэж эхлэх санал хураахад заавал бүрдүүлсэн байвал зохино.

4. Чуулганы хуралдаан, Байнгын хороодын дагнасан буюу хамтарсан хуралдааныг чуулганы ажиллагаанд тооцно.

5. Улсын Их Хурал хууль, бусад шийдвэрийг гагцхүү чуулганы хуралдаанаар батлан гаргана.

8 дугаар зүйл. Улсын Их Хурлын анхдугаар чуулган

Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг Улсын Их Хурлын сонгууль явуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гаргаж товлон зарлана.

9 дүгээр зүйл. Ээлжит чуулган

1. Үндсэн хуулийн хорин долдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа 75-аас доошгүй ажлын өдөр хуралдана. Улсын Их Хурлын намрын чуулганыг 10 дугаар сарын 1-ний өдөр, хаврын чуулганыг 4 дүгээр сарын 5-ны өдөр тус тус нээнэ. Улсын Их Хурлын ээлжит чуулган нээх өдөр нь амралт, баяр ёслолын өдөртэй давхцвал дараагийн өдөрт шилжүүлнэ.

2. Улсын Их Хурлын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллын талаар Улсын Их Хурлын дарга ээлжит чуулган эхлэхээс 7-гооц доошгүй хоногийн өмнө захирамж гаргана.

10 дугаар зүйл. Ээлжит бус чуулган

1. Ээлжит чуулганы чөлөө цагт зайлшгүй шалтгаанаар ээлжит бус чуулган хуралдаж болно.

2. Ээлжит бус чуулганыг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны нэгээс дээшхийн шаардсанаар, эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргын санлаачилгаар хуралдуулна.

3. Улсын Их Хурлын дарга нь ээлжит бус чуулганыг товлон зарлаж, энэ тухай захирамж гаргана.

11 дүгээр зүйл. Онцгой чуулган

1. Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл байдал Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт бий болсон, эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч онц болон дайны байдал зарласан бол түүнээс хойш 72 цагийн дотор Улсын Их Хурал онцгой чуулган товлдохгүйгээр, тухайлбал Улсын Их Хурлын гишүүд зар мэдээ хүлээлгүйгээр хүрэлцэн ирж хуралдана.

2. Улсын Их Хурлын онцгой чуулганаар онц болон дайны байдал зарласан тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг уг зарлиг гарснаас хойш 7 хоногийн дотор батлах, эсхүл хүчингүй болгох, түүнчлэн тухайн нөхцөл байдлаас үүссэн хойшлуулшгүй бусад асуудлыг шийдвэрлэнэ.

3. Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус чуулган хуралдаж байх үед онц болон дайны байдал зарлах онцгой нөхцөл үүсвэл тухайн

чуулганаар хэлэлцэх аливаа асуудлыг хойшлуулж онц болон дайны байдал зарлах тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

**12 дугаар зүйл. Улсын Их Хурлын Байнгын хороо,
түүний бүтэц**

1. Улсын Их Хурлын Байнгын хороо /цаашид "Байнгын хороо" гэх/ нь Улсын Их Хурлын ажлын зохион байгуулалтын хэлбэр мөн.

Байнгын хороо нь чуулганаар хэлэлцэх асуудал боловсруулах, урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргах, түүнчлэн эрхлэх асуудлынхаа хүрээнд Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх нийтлэг чиг үүрэгтэй.

2. Улсын Их Хурал Байнгын хороог үйл ажиллагааныхаа салбар, чиглэлээр байгуулах бөгөөд дараахь Байнгын хороотой байна:

1. Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн;
2. Нийгмийн бодлогын;
3. Төрийн байгуулалтын;
4. Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын;
5. Хууль зүйн.

**13 дугаар зүйл. Байнгын хорооны бүрэн эрх,
эрхлэх асуудал**

1. Байнгын хороо тус тусын эрхлэх асуудлын хүрээнд дараахь бүрэн эрхтэй:

1/Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, бусад шийдвэрийн төслийн талаар санал, дүгнэлт гаргах;

2/Улсын Их Хурлаар хэлэлцэх тодорхой асуудлуудаар санал, дүгнэлт гаргах;

3/Улсын Их Хурлын даалгаснаар, эсхүл өөрийн санаачилгаар Монгол Улсын Засгийн газар /цаашид "Засгийн газар" гэх/-т санал оруулах, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр биелүүлэх талаар шаардлага тавих;

4/ хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтэд болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх;

5/Засгийн газар, түүний гишүүн, Улсын Их Хурлаас байгуулагдах бусад байгууллагын эрх баригчдын мэдээллийг сонсож хэлэлцэх, асуулт, асуулга тавьж, хариулт авах, тэднийг томилох, сонгох, огцруулах тухай санал дүгнэлт гаргах;

6/Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх асуудлаар болон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийн талаар судалгаа, тайлан, мэдээ, дүгнэлт зэрэг баримт салтийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах, тэдний мэдээллийг сонсох;

7/Улсын Их Хурлаас тавих хяналтыг хэрэгжүүлэх, хуулийн төслийн талаар дүгнэлт гаргахад туслалцаа авах зорилгоор мэргэжлийн байгууллага болон олон нийтээс санал авах, шинжээч, мэргэжилтнээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах.

2.Байнгын хороо дараахь эрхлэх асуудлын хүрээнд бүрэн эрхээ хэрэгжүүлнэ:

1/Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн байнгын хороо:

-Газар, түүний хэвтий, ой, ус, амьтан, ургамал, агаар мандал болон байгалийн бусад баялаг;

-Геологи, эрдэс, түүхий эдийн бодлого;

-ашигт малтмал олборлолт;

-улсын тусгай хамгаалалттай газар, бэлчээр, тариалангийн газар;

-газрын тосны эрэл хайгуул, судалгаа, олборлолт;

-геологи, уул уурхай байгаль орчны төрийн хяналт;

-агаарын бохирдол, хорт бодис байгаль орчны асуудал;

-усны бодлого, нөөц, усны бохирдол;

-хог хаягдал, дахин боловсруулалт;

-байгаль орчны бодлого;

-байгаль орчны судалгаа, хөгжил;

-ан агнуур;

-газар тариалан, хүнсний үйлдвэрлэл, хангамж;

-хүнсний хяналт, аюулгүй байдал;

-үрийн аж ахуй;

-мал аж ахуйн бодлого;

-мал, мах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хяналт ;

-малын өвчин;

-малын даатгал.

2/Нийгмийн бодлогын байнгын хороо:

-боловсрол;

-соёл, урлаг;

-шинжлэх ухаан, технологийн хөгжил;

-ард түмний түүх, соёл, оюуны өвийг сэргээх, хамгаалах талаархи бодлого;

-монгол хэл, бичиг, үндэстний цөөнхийн хэл, бичиг, соёл, урлаг, ёс заншлын талаар төрөөс баримтлах бодлого;

-хүн амын бодлого;

-хүн амын эрүүл мэнд;

-хөдөөгийн нийгмийн бодлого;

-нийгмийн даатгал, хангамж, халамж;

-нийтийн биеийн тамир, спорт;

-хөдөлмөр эрхлэлт;

-хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр хамгаалал.

3/Төрийн байгуулалтын байнгын хороо:

-төрийн эрх барих дээд болон гүйцэтгэх дээд байгууллага, Ерөнхийлөгчийн байгуулалт;

-Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль;

-Монгол Улсын хил, түүний хамгаалалт;

-Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хилийн цэс, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа;

-төрийн алба;

-төрийн бэлгэ тэмдэг, төрийн дуулал;

-гадаад бодлого;

-гадаадад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох асуудал;

-Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улс олон улсын байгууллагад элсэх асуудал;

-Монгол Улсын үндэсний аюулгүй байдал;

-Монгол Улсын батлан хамгаалах, зэвсэгт хүчин;

-ард нийтийн санал асуулга;

-төр, сүм хийдийн харилцаа;

-хэвлэл, мэдээллийн хэрэгсэл;

-улс төрийн нам, төрийн байгууллага;

-Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн асуудал;

-Улсын Их Хурлын гишүүний ёс зүй;

-Улсын Их Хурлын гишүүний хөдөлмөр, ахуйн асуудал;

-Улсын Их Хурал, нам, эвслийн бүлгийн болон Улсын Их Хурлын гишүүний төсвийн хяналт;

-Улсын Их Хурлын гишүүний орлогын мэдүүлэг;

-Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн биелэлт.

4/Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын байнгын хороо:

-улсын төсөв, төсвийн орлого, зарлага;

-төсвийн хяналт;

-төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого;

-эдийн засгийн гадаад, дотоод бодлого;

-улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн жилийн үндсэн чиглэл;

-төрийн өмчийн асуудал;

-эдийн засгийн тогтвортой байдал;

-гадаад худалдаа, экспортын хяналт;

-банк, монголбанкны үйл ажиллагаа;

-шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах, худалдааг хамгаалах асуудал;

- төрийн зээлийн хэлбэл;
- төрөөс аж ахуй эрхлэхийг дэмжих бодлого;
- Улсын Их Хурлын төсөв;
- эрчим хүчний бодлого;
- хэмжил зүй, стандартчилал, чанарын баталгаажуулалт;
- гадаадын хөрөнгө оруулалтын асуудал;
- гадаадын зээл, буцалтгүй тусламжийн зарцуулалт, ашиглалт;
- статистик;
- стандартчилал, хэмжил зүйн асуудал;
- барилга, хот байгуулалт, хотын хөгжил;
- аялал, жуулчлал;
- түлш, эрчим хүч;
- зам, тээвэр;
- харилцаа холбоо.

5/Хууль зүйн байнгын хороо:

- Монгол Улсын эрх зүйн бодлого;
- хүний эрх, эрх чөлөө түүний баталгаа, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого;
- хэвлэл, мэдээллийн эрх чөлөө;
- хууль зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэс, ялын бодлого;
- шүүх, прокурор, мөрдөн байцаах, хорих байгууллага;
- нийтийн болон хувийн өмчийн эрх зүйн үндэс;
- эрүү, иргэн, захиргааны байцаан шийтгэх ажиллагаа;
- өршөөл үзүүлэх асуудал;
- патент, зохиогчийн эрх, худалдааны тэмдгийн асуудал;
- цагаачлал, иргэний харьяатын асуудал;
- архив;
- эрх зүйн сурталчилгаа;
- эрх зүйн тусалцаа;
- өмгөөллийн асуудал;
- үл хөдлөх хөрөнгийн бүртгэл.

14 дүгээр зүйл. Байнгын хорооны ажлын зохион байгуулалт

1. Байнгын хорооны ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан мөн.

2. Байнгын хороо эрх хэмжээнийхээ асуудлыг хуралдаанаар хэлэлцэж, оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хуралдааныг Байнгын хорооны нийт гишүүний дийлэнх олонхи буюу гуравны хоёр нь хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөрт тооцно.

3. Байнгын хороо шийдвэрлэсэн асуудлаараа дүгнэлт, тогтоол гаргана.

4. Байнгын хорооны хуралдааны явцыг протоколд нэг бүрчлэн тэмдэглэнэ.

15 дугаар зүйл. Улсын Их Хурлын дэд хороо

1. Улсын Их Хурал зохих Байнгын хороонд харьяалагдах дор дурдсан дэд хороотой байна:

1/ Төрийн байгуулалтын байнгын хороонд:

а/ Ёс зүйн;

б/ Аюулгүй байдлын,

2/ Хууль зүйн байнгын хороонд:

Хүний эрхийн.

3/ Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын байнгын хороонд:

Төсвийн зарлагын хяналтын.

2. Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл өөр дэд хороо байгуулж болно.

3. Дэд хороо нь харьяалагдах Байнгын хорооныхоо эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцаж асуудал боловсруулах, санал, дүгнэлт гаргах, түүнийгээ харьяалагдах Байнгын хороогоороо уламжлан Улсын Их Хуралд оруулах болон хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

4. Дэд хороо дараахь асуудлыг эрхэлнэ:

1/ Ёс зүйн дэд хороо:

- Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн асуудал;

- Улсын Их Хурлын гишүүний ёс зүй;

- Улсын Их Хурлын чуулганы дэгийн биелэлт;

- Улсын Их Хурлын гишүүний орлогын мэдүүлэг.

2/ Аюулгүй байдлын дэд хороо:

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдал;

- Монгол Улсын батлан хамгаалах, зэвсэгт хүчин;

- Монгол Улсын хил, түүний хамгаалалт.

3/ Хүний эрхийн дэд хороо:

- Хүний эрх, эрх чөлөөний баталгаа;

- Өршөөл үзүүлэх асуудал;

- Цагаачлал, иргэний харьяатын асуудал.

4/ Төсвийн зарлагын хяналтын дэд хороо:

- төсвийн орлого, зарлага;

- төсвийн хяналт.

5. Ёс зүйн болон Төсвийн зарлагын хяналтын дэд хороо өөрсдийн эрхэлж буй асуудлаар гаргасан санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд бие даан оруулж болно.

6. Дэд хороо нь тухайн эрхэлсэн асуудлаараа шалгалт, судалгаа хийх, холбогдох мэдээллийг авах, зохих албан тушаалтан, иргэд,

байгууллагаас тайлбар авах, өөрийн байгуулсан дагнасан буюу хамтарсан бүрэлдэхүүн бүхий ажлын хэсгээр хяналт, шалгалт хийлгэх, эрхэлсэн асуудлаар тогтоол, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулж Байнгын хорооныхоо, эсхүл Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх эрх хэмжээтэй байна.

7. Дэд хорооны даргыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар сонгох бөгөөд Төсвийн зарлагын хяналтын болон Ёс зүйн дэд хороодын даргыг Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлэгт ордог Улсын Их Хурлын гишүүдээс сонгоно. Дэд хорооны даргын бүрэн эрхийн хугацаа 1 жил байх ба түүнийг улируулан сонгож болно.

8. Дэд хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан мөн. Дэд хороо эрхэлсэн асуудлаа хуралдаанаараа хэлэлцэж гишүүдийнхээ олонхийн саналаар шийдвэртэнэ. Хуралдааныг дэд хорооны гишүүдийн дийлэнх олонх нь хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөрт тооцно.

**16 дугаар зүйл. Улсын Их Хурлын бусад хороо,
ажлын хэсэг**

1. Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ тодорхой асуудлыг судлан боловсруулах, шийдвэрлэх, дүнг Улсын Их Хуралд оруулах зорилгоор түр хороо байгуулан ажиллуулж болно. Түр хороо зөвхөн Улсын Их Хурлын гишүүнээс бүрдэх бөгөөд түүний тоог тухайн үед тогтооно. Түр хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд Байнгын хороотой ажил эрх эдэлнэ.

2. Улсын Их Хурал шаардлагатай гэж үзсэн асуудлаар холимог болон дагнасан бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

**17 дугаар зүйл. Улсын Их Хурал дахь нам
/эвсэл/-ийн бүлэг**

1. Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудалтай нам /эвсэл/ бүлэг /цаашид "нам, эвслийн бүлэг" гэх/ байгуулж болно. Нам, эвслийн бүлэгт зөвхөн тухайн нам, эвслээс нэрийг нь дэвшүүлж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд орно.

Улсын Их Хурлын сонгуульд эвсэл байгуулж оролцсон намууд Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал эзэлбэл Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 19 дүгээр зүйлийн 2-т зааснаар эвслийн нэг бүлэг байгуулна.

2. Улсын Их Хуралд 8-аас доош суудал эзэлсэн хэд хэдэн намыг голлоож буй гишүүд нийлж намын нэг бүлэг байгуулж болохгүй. Харин гэдгээр нь аль нэг нам, эвслийн бүлэгт нэгдэж болох бөгөөд хэрэв нам, эвслийн бүлгээс гарах, шилжих бол тухай бүр Улсын Их Хурлын гаргад мэдэгдэнэ.

3.Аль нэг нам, эвслийн бүлгийн гишүүн уг нам, эвслийн бүлгийн харьяалтаас татгалзсан тохиолдолд эвслийн бүлгээс албан ёсоор гарч өөр бүлэгт нэгдэн орж болно. Ийнхүү нам, эвслийн бүлгээс албан ёсоор гарах тухайгаа тухайн нам, эвслийн бүлгийн ахлагчид урьдчилан мэдэгдсэн байна.

4.Нэрээ бие даан дэвшүүлж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн аль нэг нам, эвслийн бүлэгт нэгдэж болох боловч дангаараа бүлэг байгуулж болохгүй.

5.Нам, эвслийн бүлэг ахлагчаа гишүүдийнхээ дотроос сонгож энэ тухайгаа Улсын Их Хуралд албан ёсоор мэдэгдэнэ.

6.Нам, эвслийн бүлгийн ахлагч Улсын Их Хурлын анхдугаар чуулган дээр Улсын Их Хурлын даргыг сонгогдсоноос хойш 24 цагийн дотор нам, эвслийн бүлэг байгуулсан тухай шийдвэр, нэрсийн жагсаалтыг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлнэ.

7.Улсын Их Хурлын дарга нам, эвслийн бүлгээс өргөн мэдүүлсэн баримт бичгийг үндэслэн нам, эвслийн бүлгийг бүртгэж, энэ тухай Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дээр албан ёсоор зарлана. Шинээр нөхөн сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн аль нэг нам, эвслийн бүлэгт эвсэн нэгдвэл, түүнийг тухайн нам, эвслийн бүлгийн ахлагч бүлэгтээ бүртгэн авч, энэ тухай шийдвэр гаргана. Уг шийдвэрийг гишүүний өргөдлийн хамт гишүүний бүрэн эрх нь эхэлснээс хойш 24 цагийн дотор Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дээр албан ёсоор мэдээлнэ.

8.Улсын Их Хуралд суудал бүхий аль нэг нам гарах буюу намууд эвслээ цуцалбал тухайн нам, эвслийн бүлгийн үйл ажиллагаа дуусгавар болсонд тооцно.Нам гарсан буюу намууд эвслээ цуцалсан тухай шийдвэрийг, энэхүү шийдвэр гарснаас хойш 72 цагийн дотор Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дээр, чуулган хуралдаагүй үед энэхүү шийдвэр гараал ээлжит чуулган эхэлсэн өдрөөс хойш 72 цагийн дотор чуулганы хуралдаан дээр тус тус мэдэгдэнэ.

9.Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг 2 гишүүнд орон тооны нэг ажилтан байхаар тооцож тогтоосон ажлын албатай байж болно. Ажилтнууд нь тухайн нам, эвслийн бүлгийн ажлын албанд харьяалагдана.

Нам, эвслийн бүлгийн гишүүдийн тоог харгалзан унаа, албан томилолт, бичиг хэргийн зардал, орон тооны ажилтны цалингийн санд Улсын Их Хурлын төсөвт тусгана.

10.Нам, эвслийн бүлэг батлагдсан төсвөө зохих журмын дагуу зарцуулах бөгөөд түүнд Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хяналт тавина.

11. Нам, эвслийн бүлгийг ажиллах нөхцөлөөр хангах асуудлыг Улсын Их Хурлын Тамгын газар хариуцна.

12. Аль ч нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй Улсын Их Хурлын гишүүнд Тамгын газрын хавсарган томилсон ажилтан туслалцаа үзүүлнэ.

13. Нам, эвслийн бүлэг Улсын Их Хурлын бүгдийн хэсгийн хувьд эрхлэх ажлаа намынхаа төв байгууллагын удирдлагын өмнө шууд хариуцахгүй.

18 дугаар зүйл. Нам, эвслийн бүлгийн эрх, үүрэг

1. Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг дараахь эрх, үүрэгтэй:

1/Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэж байгаа хуулийн болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн үндэслэл, бодлогын талаар тус тусын санал, дүгнэлт гаргах;

2/чуулган, Байнгын хорооны үйл ажиллагаанд өөрийн бүлгийн гишүүдийг татан оролцуулж, хуралдааны дэгийг чанд сахиулах;

3/чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах санал гаргах;

4/Улсын Их Хурлын чуулган, Байнгын хорооны хуралдааны үед завсарлага авах;

5/бүлгийн төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлэх;

6/Байнгын хорооны бүрэлдэхүүний талаар Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх;

7/Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбогдсон саналаа Улсын Их Хурал, Байнгын хороонд оруулах;

8/чуулганаар хэлэлцэж буй асуудлаар нам, эвслийн бүлгийн байр суурийг боловсруулах ажлын хэсэг байгуулж ажиллуулах.

2. Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн бусад эрх, үүргийг Улсын Их Хурал хуулиар тогтоож болно.

3. Улсын Их Хуралд 8-аас доош суудал эзэлсэн нам, эвслийг төлөөлж байгаа Улсын Их Хурлын гишүүн дараахь эрх, үүрэгтэй:

1/Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааны дэгийг чанд сахиж;

2/Байнгын хорооны бүрэлдэхүүнд орох тухай асуудлаа Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх;

3/Улсын Их Хурлын зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон саналаа Улсын Их Хурал, харьяалагдах Байнгын хороонд оруулах.

19 дүгээр зүйл. Улсын Их Хурал дахь олонхи ба цөөнх

1. Улсын Их Хурлын нийт гишүүний олонхи буюу 38-аас дээш суудал авсан нам буюу эвслийг Улсын Их Хурал дахь олонхи /цаашид "олонхи" /-д тооцно.

2. Улсын Их Хурлын нийт гишүүний 39-өөс доош суудал авсан нам буюу эвслийн бүлэг, гишүүнийг Улсын Их Хурал дахь цөөнх /цаашид "цөөнх"/-д тооцно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Улсын Их Хурлын бүрэлдэхүүн

20 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэлдэхүүн

Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн хорин нэгдүгээр зүйлийн 1,2,3 дахь хэсэгт зааснаар нэг танхимтай, Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд, нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгосон 76 гишүүнээс бүрдэнэ.

21 дүгээр зүйл. Улсын Их Хурлын гишүүн, түүний эрх, үүрэг

Улсын Их Хурлын гишүүний эрх, үүрэг, бүрэн эрхийн баталгааг Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулна.

22 дугаар зүйл. Улсын Их Хурлын даргын чиг үүрэг

1. Улсын Их Хурлын дарга нь Улсын Их Хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажлыг бүхэлд нь уялдуулан зохицуулж, дараахь ажлыг биечлэн эрхэлнэ:

1/Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус чуулган зарлаж, балтгэлийг хангах;

2/чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох;

3/чуулганы хуралдаан даргалж, хуулийн төсөл, бусад асуудал хэлэлцүүлэх;

4/бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь Улсын Их Хурлын гишүүдэд туслалц;

5/Улсын Их Хурлаас Засгийн газрын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

6/Улсын Их Хурлын үйл ажиллагаанд Үндсэн хууль, бусад хуулийг сахин биелүүлэх ажлыг зохион байгуулах;

7/Улсын Их Хурлаас нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагатай Засгийн газраар дамжуулан харилцах асуудлыг уялдуулан зохицуулах;

8/Улсын Их Хурлын гадаад харилцааны ажлыг зохицуулах;

9/Улсын Их Хурлын даргад хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хариуцуулж болно.

2. Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлыг төлөөлнө.

3. Улсын Их Хурлын дарга төрийн хамгаалалтад байна. Улсын Их Хурлын даргын орон сууц, унааны зардлыг төрөөс хариуцах бөгөөд түүний бие, өргөө, унаа халдашгүй дархан байна.

4. Улсын Их Хурлын дарга эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргана.

23 дугаар зүйл. Улсын Их Хурлын дэд даргын чиг үүрэг

Улсын Их Хурлын дэд дарга дараахь ажлыг биечлэн эрхэлнэ:

1/ Улсын Их Хурлын даргын эзгүйд түүний үүргийг гүйцэтгэх;

2/ Улсын Их Хурлын Байнгын хороод, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

3/ Улсын Их Хурлын даргаас даалгасан бусад ажил.

24 дүгээр зүйл. Байнгын хорооны бүрэлдэхүүн

1. Байнгын хороо нь 12-оос доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Улсын Их Хурлын гишүүн нэгэн зэрэг 2 Байнгын хорооны гишүүнээр сонгогдон ажиллаж болно.

2. Байнгын хороог Улсын Их Хурлаас 1 жилийн хугацаатай сонгогдсон дарга тэргүүднэ. Байнгын хорооны даргыг улируулан сонгож болно.

3. Байнгын хорооны дарга хорооныхоо өдөр тутмын ажлыг удирдаж, хуралдааныг даргална. Байнгын хорооны даргын эзгүйд түүний саналыг харгалзан Улсын Их Хурлын даргын захирамжаар томилсон нэг гишүүн үүргийг нь орон гүйцэтгэнэ.

25 дугаар зүйл. Байнгын хорооны даргын эрх хэмжээ

Байнгын хорооны дарга дараахь ажлыг биечлэн эрхэлнэ:

1/ Байнгын хорооны хуралдааныг бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулах;

2/ Байнгын хорооны хуралдааныг удирдах;

3/ Байнгын хорооны нэрийн өмнөөс бусад байгууллагатай харьцах;

4/ Байнгын хорооны ажлын алба болон тодорхой төслийг боловсруулахаар Байнгын хорооноос байгуулсан ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

5/ Байнгын хорооны ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцан тайлагнах.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

26 дугаар зүйл. Улсын Их Хурлын ажлын нөхцөл

1. Улсын Их Хурал "Төрийн ордон"-д байрлана.

2. Улсын Их Хурал аж ахуй, санхүүгийн хувьд бие даасан байна.

3. Улсын Их Хурлын төсвийн зарцуулалтад Төрийн байгуулалтын байнгын хороо хяналт тавина.

4. Улсын Их Хурал нь өөрийн гишүүд, Байнгын болон бусад хорооны үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх болон ажиллах нөхцөлөөр хангах үүрэг бүхий Тамгын газартай байна.

27 дугаар зүйл. Улсын Их Хурлын Тамгын газар,
түүний эрхлэх ажил

1. Улсын Их Хурлын Тамгын газар /шашид "Тамгын газар" гэх/ нь дараахь ажлыг эрхлэн гүйцэтгэнэ:

1/Улсын Их Хурал, түүний гишүүд, Байнгын болон бусад хороодын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн туслалцаа болон бусад ажиллах нөхцөлөөр хангах;

2/Улсын Их Хурлын аж ахуй, санхүүг хотлон явуулах, түүний төсвийг зохих журмын дагуу зарцуулах;

3/Улсын Их Хурлын чуулганы бэлтгэл, хуралдааны хэвийн ажиллах нөхцөлийг хангах;

4/чуулганы болон хороо, ажлын хэсгийн хуралдааны танхим, шаардлагатай техник, хэрэгслийг бэлэн байлгах, танхимд журам сахуулах;

5/хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, баримт бичгийг нийтлүүлэх, тараах ажлыг зохион байгуулах;

6/Улсын Их Хуралд иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;

7/Улсын Их Хурлын гишүүдийг шаардлагатай мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;

8/Улсын Их Хурлын бичиг хэрэг, архивын үйл ажиллагааг хотлон явуулах;

9/Улсын Их Хурал, Тамгын газар, түүний харьяа байгууллагын гадаад харилцааны асуудлыг хариуцан шаардлагатай баримт бичиг бэлтгэх, Улсын Их Хурлын шугамаар гадаад оронд айлчлах болон гадаадаас ирэх төлөөлөгчдийг хүлээн авах, бэлтгэл хангах, гадаадын зочин, төлөөлөгчдөд үйлчлэх;

10/хууль болон Улсын Их Хурлын бусад шийдвэрээр даалгасан бусад үүргийг биелүүлэх.

2. Улсын төсвийн төсөл боловсруулах, батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих, Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг Тамгын газарт байна.

3. Улсын Их Хурлын даргад туслах ажлын хэсэг Тамгын газарт багтах бөгөөд Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга /цаашид "Ерөнхий нарийн бичгийн дарга" гэх/-ын шууд харьяанд байж Улсын Их Хурлын даргад үйлчилнэ.

4. Тамгын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ажилтны цалинг Улсын Их Хурлаас баталсан санд багтаан Ерөнхий нарийн бичгийн дарга Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн тогтооно.

5. Тамгын газар нь хуулийн этгээд мөн бөгөөд өөрийн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

28 дугаар зүйл. Ерөнхий нарийн бичгийн дарга

1. Улсын Их Хурлын чуулган бэлтгэн явуулах, түүний өдөр тутмын ажлыг зохицуулахад Улсын Их Хурлын даргад туслах, Улсын Их Хурлын Тамгын газрыг удирдах үндсэн үүрэг бүхий Ерөнхий нарийн бичгийн даргыг Улсын Их Хурлаас томилно.

2. Ерөнхий нарийн бичгийн дарга нам бус байна.

3. Ерөнхий нарийн бичгийн дарга эрхлэх асуудлаараа захирамж гаргана.

29 дүгээр зүйл. Ерөнхий нарийн бичгийн даргын эрхлэх ажил

1. Ерөнхий нарийн бичгийн дарга дараахь ажлыг эрхлэн гүйцэтгэнэ:

1/ Улсын Их Хурлын чуулганы хуралдааны техник, зохион байгуулалтын бэлтгэл ажлыг зохион байгуулж хангах;

2/ Улсын Их Хурлын чуулганы хуралдаан даргалагчид зөвлөх, хэлэлцэж буй асуудлын талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх;

3/ Улсын Их Хурал, түүний даргад байгууллага, иргэдээс ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;

4/ Улсын Их Хурлын дарга, гишүүд иргэдийг хүлээн авах ажлыг зохион байгуулах;

5/ Тамгын газар, түүний харьяа байгууллагын боловсон хүчний бодлого боловсруулах;

6/ Тамгын газрыг удирдаж, түүнд ажиллах боловсон хүчинг гомилох, чөлөөлөх.

2. Ерөнхий нарийн бичгийн даргын эрхлэх бусад ажлын чиг үүргийг Улсын Их Хурал тогтооно.

30 дугаар зүйл. Улсын Их Хурлын шийдвэр

Улсын Их Хурал хууль, бусад шийдвэр гаргана. Улсын Их Хурлын бусад шийдвэр нь тогтоол хэлбэрээр гарах бөгөөд тогтоолоор дараахь асуудлыг шийдвэрлэнэ:

1/ зохион байгуулалтын;

2/ нэг удаагийн чанартай;

3/Засгийн газар болон бусад байгууллагад гүйцэтгэх асуудлаар үүрэг, даалгавар өгөх.

31 дүгээр зүйл. Улсын Их Хурлын тамга,
тэмдэг, хэвлэмэл хуудас

Улсын Их Хурал нь тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА**

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 2 дугаар
сарын 6-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ДЭГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдсаныг /шашид "хуралдаан" гэх/ зохион байгуулах, хуралдаанаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, тодорхой асуудлыг хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргах, биелэлтэд хяналт тавих зэргээр Улсын Их Хурлаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хуралдааны дэгийн тухай хууль тогтоомж

Хуралдааны дэгийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуралдааны үндсэн зарчим

Хуралдааны ажиллагаа хууль дээдлэх, асуудлыг чөлөөтэй хэлэлцэх цөөнхийн санаа бодлыг хүндэтгэж олонхийн саналаар шийдвэртээ заримд үндэслэнэ.

4 дүгээр зүйл.Хуралдааны нийтлэг журам

1.Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг Үндсэн хуулийн хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар нийт гишүүний дийлэнх олонхи буюу гуравны хоёр нь хуралцан ирснээр хүчинтэйд тооцно.

2.Улсын Их Хурлын гишүүд хуралдаан эхлэх цаглас өмнө суудлаа эзэлсэн байна.

3.Улсын Их Хурлын гишүүд чуулганы хуралдаанд оролцохдоо хуралдааны дэгийг сахих үүрэгтэй бөгөөд уг хэлэхдээ дарваахь журам баримтална:

1/хуралдаан даргалагчаас зөвшоорол авах;

2/чуулганы хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн уг хэлэх хугацаа 5 минутаас илүүгүй байх;

3/уг хэлэх хугацааг бусдад шилжүүлэхгүй байх.

4 Монгол Улсын Ерөнхийлөгч хуралдаанд өөрийн талллар оролцож уг хэлж болно.

Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, ерөнхий прокурор, Үндсэн хуулийн цэцийн дарга чуулганд зөвлөх эрхтэй оролцож болно.

5.Улсын Их Хурлаас байгууллааг бусад байгууллагын эрх баригчид, хэлэлцэж байгаа асуудал хариуцсан Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтан, ажлын хэсгийн гишүүд, хуралдаанд байлцаж болно.

6.Улсын Их Хурлын даргын урилглар хуралдаанд бусад хүмүүсийг байлцуулж болно.

7.Энэ зүйлийн 4, 5 дахь хэсэгт дурдсан хүмүүс хуралдаан даргалагчийн зөвшоорсноор уг хэлж болно.

8.Хуралдаанд иргэд, дотоод, гадаадын зочид, төлөөлөгчид, хэлэлц, мэдээллийн байгууллагын ажилтан зохих журмын дагуу байлцаж болно Энэ журмыг Улсын Их Хурлын дарга тогтооно.

9. Улсын Их Хурлын хуралдаан нээлттэй байна. Улсын Их Хурлын хуралдааны явц, шийдвэрийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

10.Хэлэлцэх асуудлын шинж байдлыг харгалзан чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг хаалттай явуулж болно. Асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэхэд дарваахь журмыг баримтална:

1/улсын нууцын жагсаалтад хамаарах асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ. Уг жагсаалтад ороогүй асуудлыг хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналлар хаалттай хуралдаанаар хэлэлцэж болно;

2/хаалттай хуралдаанд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга /цаашид "Ерөнхий нарийн бичгийн дарга" гэх/, түүний орлогч, Тамгын газрын

нууцны асуудал хариуцсан ажилтан, тухайн асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсгийн гишүүдээс бусад хүн байлцах асуудлыг Улсын Их Хурлын даргын баталсан журмын дагуу Ерөнхий нарийн бичгийн дарга зохицуулна. Хаалттай хуралдаанд оролцох хүмүүсийн нэрсийг урьдчилан гаргасан байх бөгөөд шаардлагатай бол тэднээр хэлэлцэх асуудлын нууц задруулахгүй байх баталгаа гаргуулна;

3/хаалттай хуралдаанд албан ёсоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд бичлэг хийх, дуу хураагч, гар утас авч орох, утсаар ярихыг хориглоно;

4/Ерөнхийлөгч, Ерөнхий сайдаас бусад Улсын Их Хурлын чуулганд зөвлөх эрхтэй оролцож болох албан тушаалтныг хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар хаалттай хуралдаанд байлцуулна;

5/хаалттай хуралдааны талаар зөвхөн нууцны дэвтэрт тэмдэглэл хийнэ;

6/хаалттай хуралдааны талаар энэ хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу нийтэд мэдээлж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Чуулганы хуралдааны дэг

5 дугаар зүйл.Хуралдаанаар хэлэлцэх асуудал

1.Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.Зөвхөн Байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргаагүй асуудлыг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд оруулж болохгүй.

2.Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх асуудлын талаар чуулганы хуралдаанаар урьдчилан хэлэлцэх бөгөөд хэлэлцүүлгийн дүнг үндэс тэн Улсын Их Хурлын дарга чуулганаар хэлэлцэх асуудлын тухай захирамж гаргаж, дарааллыг тогтооно.

3.Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, Улсын Их Хурлын гишүүн хуралдаанд шинээр асуудал хэлэлцүүлэх тухай саналаа Улсын Их Хурлын даргад бичгээр буюу амаар гаргаж болно.

4. Чуулган, Байнгын хороогоор хэлэлцэх асуудлыг нам, эвслийн бүлэг урьдчилан хэлэлцсэн байлал зохино.Хүндэтгэн үзэхээс бусад шалтгаанаар нам, эвслийн бүлэг чуулган, Байнгын хороогоор хэлэлцэх асуудлыг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргаагүй нь уг асуудлыг чуулган, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхгүй байх үндэслэл болохгүй.

5.Чуулганы хуралдаанаар хэлэлцэх тодорхой асуудлыг эрс эсэргүүцсэн Улсын Их Хурлын гишүүн, нам, эвслийн бүлэг тухайн

асуудлыг хэлэлцэхэд оролцохгүй гэдгээ уг асуудлыг хэлэлцэж эхлэхээс өмнө хуралдаан даргалагчид албан ёсоор мэдэгдэж болно. Энэ тохиолдолд нам, эвслийн бүлэг, Улсын Их Хурлын гишүүн хуралдаанд оролцохгүй тухай шалтгаан, хугацаагаа мэдэгдэж, хуралдаан даргалагчид бичгээр өгнө. Ийнхүү чуулганы хуралдаанд оролцоогүй нь хуралдааны хүчин төгөлдөр байхад нөлөөлөхөөр бол дэгийн дагуу хуралдаанд оролцохыг шаардах, эсхүл хуралдаан завсарлах эсэхийг хуралдаан даргалагч шийдвэрлэнэ. Хуралдаан завсарласан хугацаанд нам, эвслийн бүлгийн ахлагч нар уг асуудлаар зөвшилцөнө. Зөвшилцөлд хүрч чадаагүй бол хуралдаанд оролцохгүй байх хугацаа дуусмагц тухайн гишүүн, нам, эвслийн бүлэг хуралдаандаа ирэх үүрэгтэй. Хэрэв хуралдаанд ирэхгүй бол Улсын Их Хурлын дарга хуралдаанд оролцохыг шаардсан захирамж гаргана.

6. Улсын Их Хурлын даргын захирамжаар хуралдаанд оролцохыг шаардсан боловч дээрх шалтгаанаар хуралдаанд оролцохгүй байгаа Улсын Их Хурлын гишүүнийг хуралдаан тасалсанд тооцно.

6 дугаар зүйл. Хуралдаан даргалагчийн эрх,
үүрэг

1. Хуралдаан даргалагч дараахь эрх, үүрэгтэй:

1/ хуралдааны дэгийн биелэлтэй хяналт тавьж, гишүүнээс түүнийг биелүүлэхийг шаардах;

2/ илтгэл сонсох, санал дүгнэлт гаргах, санал хураах цагийг тогтоох;

3/ саналаа ирүүлсэн дараллыг баримтлан гишүүдэд уг хэлэх зөвшөөрөл олгох;

4/ хуралдаанд оролцсон хүмүүст уг хэлэх зөвшөөрөл олгох;

5/ хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулж, дүнг мэдээлж, эцсийн шийдвэрийг сонсгон батлуулах;

6/ хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг цаг тухайд нь гаргах ажлыг зохион байгуулах;

7/ хуралдааны дэг, дотоод журам зорчигчлод энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан өргө хэмжээ авах;

8/ хэлэлцэж буй асуудлаар гишүүдийн гаргасан горимын саналыг сонсох, түүгээр санал хураалгах.

Горимын санал гэж хуралдаанаар тухайн асуудлыг хэрхэн хэлэлцэх, шийдвэрлэх талаар Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан саналыг ойлгоно. Горимын саналаар нэг удаа санал хураалгана.

2. Хуралдаан даргалагч чуулганы хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдэд танхимгаас гарах зөвшөөрөл олгоно.

3. Улсын Их Хурал хуралдаан даргалагчид бусад эрх олгож болно.

**7 дугаар зүйл. Улсын Их Хурлын хуралдааны
хуваарь**

1. Улсын Их Хурал хуралдааныг үйл ажиллагааг дараахь байдлаар зохион байгуулж явуулна:

- 1/Даваа, Бямба гаригт нам, эвслийн бүлгийн хуралдаан;
- 2/Мягмар, Лхагва гаригт Байнгын хороодын хуралдаан;
- 3/Пүрэв, Баасан гаригт Улсын Их Хурлын чуулганы хуралдаан.

2. Шаардлагатай бол Лхагва гаригийн үдээс хойш 15.00 цагаас 18.00 цаг хүртэл чуулганы хуралдаан хийж болно.

3. Байнгын хорооны хуралдааны цагийн хуваарийг Улсын Их Хурлын дэд дарга зохицуулна.

4. Улсын Их Хурлын чуулганы өглөөний хуралдааныг 9.00 цагаас 13.00 цаг хүртэл, оройн хуралдааныг 15.00 цагаас 18.00 цаг хүртэл явуулна.

Улсын Их Хурлын чуулганы өглөөний хуралдааныг 2 цаг тутам 20 минутын, оройн хуралдааныг 1 цаг 30 минут тутам 10 минутын завсарлагатай явуулна.

5. Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар долоо хоног бүрийн Баасан гаригийн 16.40 цагаас 18.00 цаг хүртэл хугацаанд Засгийн газрын мэдээлэл, Засгийн газарт тавьсан асуулга, асуултын хариуг сонсоно.

6. Тодорхой асуудал хэлэлцэх явцад шаардлагатай бол гишүүдийн олонхийн сандалар хуралдааныг түр завсарлах буюу хугацааг нь сунгаж болно.

**8 дугаар зүйл. Чуулганы дэг зөрчигчид хүлээлгэх
хариуцлага**

1. Улсын Их Хурлын гишүүн чуулганы хуралдааны үед дэг зөрчсөн, бусдыг доромжилсон бол хуралдаан даргалагч дараахь хариуцлага хүлээлгэнэ:

- 1/урьдчилан сануулах;
- 2/урьдчилан сануулга авсан гишүүн дахин зөрчил гаргавал түүний тухайн өдрийн хуралдаанд үг хэлэх эрхийг хасах;

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Тодорхой асуудал хэлэлцэж шийдвэрлэх

**9 дүгээр зүйл. Улсын Их Хурлын анхдугаар чуулганы
хуралдааныг зохион байгуулах**

1. Монгол Улсын Ерөнхийлөгч анхдугаар чуулганыг нээж үг хэлнэ.

2. Улсын Их Хурлын сонгуулийн нэгдсэн дүн, Улсын Их Хурлын шинээр сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай асуудлаар Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн Ерөнхий хорооны дарга илтгэл тавина. Илтгэлтэй холбогдуулж асуулт тавьж, хариулт авч болно.

3. Шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд тангараг өргөнө. Тангаргын үгийг Улсын Их Хурлын насаар хамгийн ахмад гишүүн уншиж бусад гишүүд давтан хэлнэ.

4. Тангараг өргөсний дараа Улсын Их Хурлын гишүүд цагаан толгойн үсгийн дарааллаар Төрийн сүлднээ мэхийн ёслол, тангаргын хуудсанд гарын үсэг зурах ёслол үйлдэнэ.

5. Шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийг тангараг өргөх ёслол үйлдэж дуустал Ерөнхийлөгч, харин Улсын Их Хурлын даргыг сонгох хүртэл Улсын Их Хурлын насаар хамгийн ахмад гишүүн чуулганы хуралдааныг даргална.

10 дугаар зүйл. Улсын Их Хурлын дарга, дэд даргыг сонгох

1. Улсын Их Хурлын дарга, дэд даргын сонгуулийг тус тусад нь, тэгэхдээ даргын сонгуулийг эхэлж явуулна.

2. Улсын Их Хуралд хамгийн олон суудал авсан нам буюу эвсэл Улсын Их Хурлын даргын сонгуульд эхэлж нэр дэвшүүлэх эрхтэй.

3. Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын дарга, дэд даргад өөрийн болон бусад гишүүний нэрийг дэвшүүлж болно.

4. Улсын Их Хурлын даргын сонгуульд зөвхөн нэг хүний нэр дэвшсэн бол нууц санал хураалт явуулж, санал хураалтад оролцсон гишүүдийн олонхийн саналаар түүнийг Улсын Их Хурлын даргаар сонгосонд тооцно. Улсын Их Хурлын даргад хоёр түүнээс дээш хүний нэр дэвшсэн бол нууц санал хураалт явуулж, санал хураалтад оролцсон гишүүдийн олонхийн санал авсан хүнийг Улсын Их Хурлын даргаар сонгосонд тооцно. Хоёр нэр дэвшигчийн талаар санал тэнцсэн буюу тэдгээрийн хэн нь ч олонхийн санал аваагүй бол санал тэнцсэн хоёр гишүүний буюу хамгийн олон санал авсан хоёр гишүүний талаар дахин нууц санал хураалт явуулна. Гурав дахь удаа санал хураахад хүрвэл энэ зүйлд заасан журмаар дахин нэр дэвшүүлнэ. Улсын Их Хурлын гишүүн санал хураалтад оролцохдоо зөвхөн нэг хүний төлөө санал өгнө.

5. Улсын Их Хурлын дэд даргын сонгуулийг явуулахад энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан журмыг баримтална.

11 дүгээр зүйл. Улсын Их Хурлын дарга, дэд даргыг үүрэгт ажлаас чөлөөлөх, огцруулах

1. Улсын Их Хурлын дарга, дэд дарга биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос үүрэгт ажлаас чөлөөлж өгөхийг хүсч, Улсын Их Хуралд өргөдөл гаргавал Улсын Их Хурал чуулганы хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

2. Улсын Их Хурлын дарга, дэд дарга гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болохыг шүүх тогтоосон, эсхүл огцруулах, эгүүлэн татах үндэслэлтэй гэж Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргаж түүнийг нь Улсын Их Хурал хүлээн зөвшөөрвөл бүрэн эрхийнх нь хугацаа дуусахаас өмнө тухайн албан тушаалаас огцруулах асуудлыг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

**12 дугаар зүйл. Улсын Их Хурлын Байнгын хороо,
бусад байгууллага байгуулах**

1. Улсын Их Хурлын дарга Байнгын хорооны бүрэлдэхүүний талаар нам, эвслийн бүлгийн ахлагч нартай зөвшилцсөнөөр Улсын Их Хурал өөрийн гишүүдээс сонгон Байнгын хороог байгуулна.

Тухайн Байнгын хороо гишүүдийнхээ дотроос Байнгын хорооны даргад нэр дэвшүүлнэ.

Улсын Их Хурлын гишүүн Байнгын хорооны даргад өөр гишүүний нэрийг дэвшүүлэх эрхтэй. Хэрэв нэг албан тушаалд гурав буюу түүнээс дээш хүний нэр дэвшвэл хүн тус бүр дээр саналыг нууцаар хурааж санал хураалтад оролцогсдын олонхийн санал авсан хүнийг Байнгын хорооны даргаар сонгогдсонд тооцно. Хэрэв нэр дэвшигчийн хэн нь ч олонхийн санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр хүнийг үлдээж, дахин санал хураалт явуулна. Санал тэмцсэн, эсхүл хэн нь ч олонхийн санал аваагүй бол сонгуулийг дахин явуулна.

2. Санал нууцаар хураах тохиолдолд уг ажлыг зохион байгуулж, дүн илтгэх үүрэг бүхий санал хураах комиссыг дарга, нарийн бичгийн даргыг оролцуулан тав хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэйгээр сонгож байгуулна. Улсын Их Хурлаас тухайн санал хураалтаар эохих албан тушаалд сонгогдох буюу томилогдохоор нэр дэвшигчийг санал хураах комиссын бүрэлдэхүүнд оруулахгүй.

3. Улсын Их Хурлын бусад байгууллагыг байгуулахад дээрх журмыг баримтална.

**13 дугаар зүйл. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг
хүлээн зөвшөөрөх**

1. Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны нэрийн өмнөөс түүнтэй дарга Үндсэн хуулийн гучин нэгдүгээр зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж

санал хураасан өдрөөс хойш 30 хоногийн дотор бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх тухай асуудлыг Улсын Их Хуралд тавина.

/Энэ хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьсан тул уг хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэтэл хуулийн энэ залт хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөхгүй болно./

2. Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хороо Ерөнхийлөгчийн сонгууль хуулийн дагуу явагдсан эсэхийг дүгнэж, санал хураалтын дүнгийн талаар Улсын Их Хуралд илтгэнэ. Уг илтгэлийг сонссоны дараа Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг сонсоно.

3. Нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай хуулийг Улсын Их Хурлын гишүүд олонхийн саналаар батална.

14 дүгээр зүйл. Ерөнхийлөгчийг чөлөөлөх

1. Ерөнхийлөгч биеийн эрүүл мэнд, хүндэтгэн үзэх бусад шалтгаан, нөхцөлийн улмаас Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлж чадахгүйгээ илэрхийлж, Улсын Их Хуралд хүсэлт гаргасан бол Улсын Их Хурал түүнийг чөлөөлөх эсэхийг хянан хэлэлцэж, хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

Ерөнхийлөгчийн хүсэлтийг хэлэлцэхдээ эхлээд түүний тайлбарыг сонсоно. Хэрэв энэ талаар Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн дүгнэлт байгаа бол тэдгээрийг Улсын Их Хуралд уншиж сонсоно. Дараа нь Улсын Их Хурлын гишүүд асуулт тавьж, санал, дүгнэлт гаргаж болно.

15 дугаар зүйл. Ерөнхий сайдыг

томилгох

1. Ерөнхийлөгч Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан журмаар нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилуулах тухай саналаа Улсын Их Хурлын даргыг сонгосноос хойш 14 хоногийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

2. Ерөнхий сайдын албан тушаалд нэг хүний нэр дэвшүүлднэ.

3. Нэр дэвшигчийг Ерөнхийлөгч танилцуулна. Нэр дэвшигчийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлтийг сонсоно. Улсын Их Хурлын гишүүд Ерөнхий сайдад нэр дэвшигчид асуулт тавьж, хариулт авч болно. Нэр дэвшигчийн талаар Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дүгнэлт гаргасны дараа саналыг нууцаар хурааж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар Ерөнхий сайдыг томилгох эсэх тухай тогтоол гаргана.

4. Ерөнхий сайдад нэр дэвшигч олонхийн санал авч чадаагүй бол 14 хоногийн дотор дахин өөр хүний нэр дэвшүүлэхийг Ерөнхийлөгчид

Улсын Их Хурал зөвлөнө Дахин нэр дэвшүүлж томилох асуудлыг энэ зүйлд заасан журмаар гүйцэтгэнэ.

5.Ерөнхий сайдыг томилсон тухай Улсын Их Хурлын тогтоол хүчин төгөлдөр болсноор Засгийн газрын бүрэн эрхийн хутагцаа эхэлж, шинэ Ерөнхий сайдыг томилсноор дуусгавар болно.

16 дугаар зүйл.Засгийн газрын гишүүдийг

ТОМИЛОХ

1.Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурал Ерөнхий сайдын санал болгосноор Засгийн газрын гишүүдийг томилж, Засгийн газрыг эмхлэн байгуулна.Ерөнхий сайд Ерөнхийлөгчтэй зөвшилцөж Засгийн газрын гишүүнд нэр дэвшүүлсэн хүн бүрийг Улсын Их Хурлын зохих Байнгын хороогоор урьдчилан хэлэлцүүлэх бөгөөд Байнгын хорооны санал, дүгнэлт гарсны дараа Улсын Их Хурал чуулганаараа хэлэлцэнэ.

2.Улсын Их Хурал Засгийн газрын гишүүнд Ерөнхий сайдын нэр дэвшүүлсэн хүн бүрийг тусад нь хэлэлцэнэ. Улсын Их Хурлын гишүүд нэр дэвшигчид асуулт тавьж, хариулт авсны дараа санал, дүгнэлтээ гаргана.Нэр дэвшигчийг Засгийн газрын гишүүнээр томилох талаар нууц санал хураалтыг хүн бүрээр явуулна.Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн санал авсан хүнийг Засгийн газрын гишүүнээр томилогдсонд тооцно.

3.Нэр дэвшигч нь Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн санал авч чадаагүй бол Ерөнхий сайд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан журмын дагуу 14 хоногийн дотор тухайн албан тушаалд өөр хүнийг нэр дэвшүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

17 дугаар зүйл.Засгийн газрыг огцруулах тухай

Улсын Их Хурлын санаачилга

1.Үндсэн хуулийн дөчин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь Засгийн газрыг огцруулахыг хүсч гарын үсэг зурсан саналаа Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлснээс хойш хорин дөрвөөс доошгүй цагийн дараа, гэхдээ 15 хоногийн дотор Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэнэ.Ийнхүү хэлэлцэхлээ Засгийн газрыг огцруулах болсон үндэслэл бүхий санал, Байнгын хороодын дүгнэлт, нам, эвслийн бүлгийн саналыг сонсоно.Уг асуудлаар Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын санал, хэрэв Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3,4-т заасан үндэслэл байна гэж үзвэл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг заавал сонсоно. Дараа нь Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, эсхүл

Засгийн газрыг огцруулахыг саналчлагч гишүүдэд асуулт тавьж, хариулт авна. Улсын Их Хурлын даргын саналаар асуулт, хариултыг тасалсны дараа санал, шүүмжлэл явуулна. Санал, шүүмжлэлийг тасалсны дараа Ерөнхийлөгч, Ерөнхий сайд уг хэлж болно.

2.Засгийн газрыг огцруулах эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы хуралданд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэртэнэ. Улсын Их Хурлын гишүүд саналаа нууцаар гаргана.

3.Улсын Их Хурлаас Засгийн газрыг огцруулахгүй гэж шийдвэртлэсэн бол ийнхүү шийдвэртлэснээс хойш 6 сарын дотор энэ асуудлыг Улсын Их Хурал дахин авч хэлэлцэхгүй.

4.Улсын Их Хурал Засгийн газрыг огцруулахаар шийдвэртлэвэл шийдвэр гаргасан өдрөөс хойш 30 хоногийн дотор шинэ Ерөнхий сайдыг томилж үүрэгтэй. <

**18 дугаар зүйл. Засгийн газрыг огцруулах тухай
Ерөнхийлөгчийн санал**

Засгийн газрыг огцруулах тухай Ерөнхийлөгчийн саналыг энэ хуулийн 17^д дугаар зүйлд заасан журмаар Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэртэнэ.

**19 дүгээр зүйл. Засгийн газар огцрох тухайгаа
өргөн мэдүүлэх**

Үндсэн хуулийн дөчин гуравдугаар зүйлийн 1,2 дахь хэсэгт зааснаар Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хэсэг нь огцрох тухайгаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол Улсын Их Хурал уг асуудлыг энэ хуулийн 17 дугаар зүйлд заасан журмаар хэлэлцэн шийдвэртэнэ. Гэхдээ Ерөнхий сайдын санал, дүгнэлтийг эхлэн сонсоно.

**20 дугаар зүйл. Улсын Их Хурал Засгийн газарт
итгэл хүдээлгэх эсэхээ илэрхийлэх**

1.Үндсэн хуулийн дөчин дөрөвдүгээр зүйлд заасны дагуу өөрт нь итгэл хүдээлгэж байгаа эсэхээ илэрхийлж өгөхийг хүсч Засгийн газар холбогдох тогтоолын төсөл Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол уг асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэж олонхийн саналаар шийдвэртэнэ. Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргана.

2.Улсын Их Хурал Засгийн газарт итгэл хүдээлгэхгүй байгаа тухай шийдвэр гаргавал Засгийн газар огцорно. Гэхдээ Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, дөчдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, мөн энэ хуулийн 15, 16 дугаар зүйлд заасан үндэслэл, журмаар шинэ Ерөнхий сайдыг томилж хүртэл тухайн Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлднэ.

**21 дүгээр зүйл. Улсын Их Хуралд Улсын дээд шүүхийн
шүүгчдийг танилцуулах**

1. Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхийн шүүгчдийг томилуулахаар Ерөнхийлөгчид санал болгохын өмнө нэр дэвшигч бүрийг Хууль зүйн байнгын хороонд танилцуулна.

2. Хууль зүйн байнгын хороо Шүүхийн ерөнхий зөвлөлөөс санал болгосон нэр дэвшигчийн талаар Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд мэдээлнэ. Улсын дээд шүүхийн шүүгчээр томилогдохоор нэр дэвшигчийн талаар Улсын Их Хурал шийдвэр гаргахгүй.

**22 дугаар зүйл. Ерөнхий прокурор, түүний орлогчийг
Ерөнхийлөгч томилохдоо Улсын Их
Хуралтай зөвшилцөх**

1. Үндсэн хуулийн тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Ерөнхий прокурор, түүний орлогчийг Ерөнхийлөгч томилохдоо Улсын Их Хуралтай зөвшилцөнө.

2. Ерөнхий прокурор, түүний орлогчоор томилогдохоор нэр дэвшсэн хүмүүсийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулна.

3. Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн санал, Хууль зүйн байнгын хорооны дүгнэлттэй танилцлаад Ерөнхий прокурор, түүний орлогчоор томилогдохоор нэр дэвшигчдийн талаар санал хураалт явуулж дүнг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

4. Ерөнхийлөгчийн санал болгосон нэр дэвшигч хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн дэмжлэг авч чадаагүй тохиолдолд Ерөнхийлөгч дахин өөр санал оруулж болно.

**23 дугаар зүйл. Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг
томилох, эгүүлэн татах**

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн гуравдугаар зүйлд зааснаар Улсын Их Хурлын дарга Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн Үндсэн хуулийн цэцийн гишүүд 3 хүний нэр дэвшүүлдэг.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нэр дэвшигч болон Үндсэн хуулийн цэцийн гишүүд Ерөнхийлөгч, Улсын дээд шүүхээс санал болгосон нэр дэвшигчийг Хууль зүйн байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулна.

3. Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар Хууль зүйн байнгын хорооны дүгнэлт, Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн саналыг сонсож нэр дэвшигч тус бүрээр

нууц санал хураалт явуулж, чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн санал авсан хүнийг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсонд тооцно.

4. Үндсэн хуулийн жаран тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг эгүүлэн татах асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэхдээ энэ талаар гарсан Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, анх нэр дэвшүүлсэн байгууллагын саналыг сонссоны дараа нууц санал хураалт явуулж, чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналтаар шийдвэртэнэ.

24 дүгээр зүйл. Гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Ерөнхийлөгч томилж, эгүүлэн татахдаа Улсын Их Хуралтай зөвшилцөх

1. Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-д зааснаар Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Ерөнхийлөгч томилж, эгүүлэн татахдаа Улсын Их Хуралтай зөвшилцөнө.

2. Гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилж, эгүүлэн татах асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо урьдчилан хэлэлцэж, санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулна.

3. Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн санал, Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлттэй танилцаад бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилж, эгүүлэн татах асуудлаар нууц санал хураалт явуулж дүнг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

4. Гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилж, эгүүлэн татах асуудлыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж, тухайн төлөөлөгчийн газрын байршилтай холбогдсон асуудлыг энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан журмаар шийдвэртэнэ.

5. Ерөнхийлөгчийн санал болгосон нэр дэвшигч хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн дэмжлэг авч чадаагүй тохиолдолд Ерөнхийлөгч дахин өөр санал оруулж болно.

25 дугаар зүйл. Ард нийтийн санал асуулга явуулах

1. Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16-д заасан ёсоор ард нийтийн санал асуулга явуулах тухай асуудлыг гагцхүү хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтны саналтаар үүсгэн хэлэлцэнэ.

2. Ард нийтийн санал асуулга явуулах асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооны болон зохих Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулна. Санал, дүгнэлтээ тусгай журмаар өргөн мэдүүлж болно.

3. Улсын Их Хурал Байнгын хороодын санал дүгнэлттэй танилцаад, ард нийтийн санал асуулга явуулах талаар санал хурааж шийдвэртэнэ.

**26 дугаар зүйл. Ерөнхийлөгчийн хоригийг
хянан хэлэлцэх**

1. Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь Ерөнхийлөгчийн тавьсан хоригийн үндэслэлийг Ерөнхийлөгч, эсхүл Ерөнхийлөгчийн илтгэмжилсэн төлөөлөгч Улсын Их Хуралд танилцуулна.

2. Ерөнхийлөгчийн хоригийн талаар тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хариуцаж байсан зохих Байнгын хороо болон Хууль зүйн байнгын хорооны дүгнэлтийг сонсоно.

Байнгын хороодын санал, дүгнэлтийг сонссоны дараа асуулт, хариулт явуулж, гишүүд санал гаргаж болно. Ийнхүү санал, дүгнэлт гаргаж дууссаны дараа Ерөнхийлөгч тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавьсныг үндэслэн уг хоригийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлаар санал хураалт явуулна. Хэрэв Ерөнхийлөгч хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн зарим хэсэгт хориг тавьсан бол тухайн зүйл, заалт нэг бүрээр санал хураалт явуулна.

3. Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн хоригийн талаар тогтоол гаргана.

4. Улсын Их Хурал хоригийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг хүчингүй болгож, эсхүл тэдгээрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэж батална.

5. Тухайн хууль, бусад шийдвэрийг хүчин төгөлдөр дагаж мөрдөж эхлэх тусгайлан заасан хугацаа Ерөнхийлөгчийн хориг тавьсан хугацаатай давхцвал хоригийг хэрхэх тухай асуудлыг Улсын Их Хурал хянан хэлэлцэж дуусах хүртэл уг хууль, бусад шийдвэр бүхэлдээ буюу түүний зарим хэсгийн үйлчлэл түр зогсоно.

6. Хориг тавьсан асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг уг шийдвэрийг баталснаас хойш 72 цагийн дотор Ерөнхийлөгчид илгээнэ.

**27 дугаар зүйл. Үндсэн хуулийн цэцийн
дүгнэлтийг хэлэлцэх**

1. Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасан асуудлын талаархи Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэхэд дараахь журмыг баримтална:

1/Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн дарга, эсхүл цэцийн аль нэг гишүүн Улсын Их Хуралд танилцуулна;

2/Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг танилцуулсны дараг тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг харгуудж байсан Байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороо дүгнэлтээ танилцуулна;

3/Улсын Их Хурлын гишүүд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт болон Байнгын хороодын дүгнэлтийн талаар асуулт тавьж, санал, дүгнэлт гаргаж болно;

4/Улсын Их Хурал Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасан асуудлаар Үндсэн хуулийн цэцийн гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх эсэхээ чуулганы хуралдаана оролцсон нийт гишүүдийн олонхийн саналаар шийдвэртэнэ;

5/Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр Үндсэн хуульд нийцэхгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал тогтоолоороо хүлээн зөвшөөрөөл тухайн хууль, шийдвэрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулна. Харин Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ, Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг Үндсэн хуульд нийцэхгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал тогтоолоороо хүлээн зөвшөөрсөн бол тэдгээр шийдвэрүүд нь хүчингүй болсонд тооцогдоно;

6/Улсын Их Хурал Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасан асуудлаар Үндсэн хуулийн цэцийн гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй бол энэ талаар Улсын Их Хурал тогтоол гаргана.

2.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн Үндсэн хууль зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэхэд дараах журмыг баримтлана:

1/Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-г мэдсэн дагуу Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний /цаашид "холбогдох албан тушаалтны" гэх/ талаар Үндсэн хуулийн цэцээс гаргасан дүгнэлтийг хэлэлцэх Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг Улсын Их Хурлын дарга даргална. Улсын Их Хурлын даргын талаар Үндсэн хуулийн цэцийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх чуулганы хуралдааныг Улсын Их Хурлын дэд дарга даргална;

2/холбогдох албан тушаалтны талаар Үндсэн хуулийн цэцээс гаргасан дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн дарга, эсхүл түүний эзгүйд орлож байгаа цэцийн аль нэг гишүүн Улсын Их Хуралд танилцуулна.

3/холбогдох албан тушаалтан цэцийн дүгнэлтийн талаар уг хэлнэ. Түүний үг 10 минутаас илүүгүй байна. Хэлсэн үгтэй нь холбогдуулан гишүүд асуулт тавьж болно;

4/холбогдох албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн тухай цэцийн дүгнэлттэй танилцсаны дараа уг албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах эсэх, тухайн зөрчлийг арилгуулах асуудлын талаар Төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлтийг хэлэлцэнэ. Шаардлагатай гэж үзвэл Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т заасан албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх талаар Улсын Их Хурал, эсхүл тухайн албан тушаалтан өөрөө Үндсэн хуулийн цэцэд хандаж болно;

5/Үндсэн хуулийн цэц тухайн албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах үндэслэл байна гэсэн дүгнэлт гаргавал түүнийг огцруулах, эгүүлэн татах эсэх асуудлыг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.Тухайн албан тушаалтныг огцруулсан, эсхүл эгүүлэн татсан нь түүнд хуулийн хариуцлага хүлээлгэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

4.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн Үндсэн хууль зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар сонсоно.

28 дугаар зүйл.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурорын талаархи Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй танилцах

Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх талаархи Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй Улсын Их Хурал танилцаж, энэ тухайгаа Ерөнхийлөгчид мэдэгдэнэ.

29 дүгээр зүйл.Ерөнхийлөгч, Засгийн газар Монгол Улсын олон улсын гэрээний төслийг Улсын Их Хуралтай зөвшилцөх

1.Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасны дагуу Ерөнхийлөгч Монгол Улсын иэрийн өмнөөс байгуулах олон улсын гэрээний мөн хуулийн гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9-д заасны дагуу Засгийн газар дэвч соёрхон батлуулах Монгол Улсын олон улсын гэрээний /шаашид "гэрээ" гэх/ төслийг Улсын Их Хуралтай зөвшилцөнө.

2.Монгол Улсын олон улсын гэрээний төслийг нөгөө талтай зарчмын хувьд тохиролцсаны дараа, түүнд гарын үсэг зурхаас өмнө Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо урьдчилан хэлэлцэнэ. Гэрээний төсөл, эсхүл түүний дэлгэрэнгүй танилцуулга,

холбогдох бусад баримт бичгийг Төрийн байгуулалтын байнгын хороо урьдчилан хэлэлцэхээс гурваас доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурлын гишүүдэд тараасан байна.

3.Бусад Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүн төслийн талаархи санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд бичгээр ирүүлэх бөгөөд уг саналыг тус Байнгын хорооны хуралдаанд заавал танилцуулна. Байнгын хорооны хуралдаанаас төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал, дүгнэлт гарвал Засгийн газар гэрээний төслийг нөгөө талтай эцэслэн тохиролцоходоо тэдгээрийг тусгах чиглэлээр ажлаж, дүнг Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулна.

4.Төрийн байгуулалтын байнгын хороо гэрээний төслийг урьдчилан хэлэлцэж дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

- 1/гэрээний төслийг бүхэлд нь зөвшөөрөх;
- 2/гэрээг байгуулах шаардлагагүй гэж үзэж татгалзах.

5.Төрийн байгуулалтын байнгын хороо гэрээний төслийг бүхэлд нь зөвшөөрсөн эсхүл уг гэрээг байгуулахаас татгалзсан тухай шийдвэр, түүнд холбогдох санал, дүгнэлтээ шаардлагатай гэж үзвэл чуулганы хуралдаанд танилцуулна.

6.Төрийн байгуулалтын байнгын хороо гэрээг байгуулах шаардлагагүй гэж үзсэн тухай шийдвэр гаргавал Ерөнхийлөгч, Засгийн газар уг асуудлыг чуулганы хуралданаар хэлэлцүүлж болно.

7.Хүчин төгөлдөр болоогүй байгаа олон улсын олон талт гэрээнд Ерөнхийлөгч Монгол Улсын нэрийн өмнөөс гарын үсэг зурахын өмнө уг асуудлыг Улсын Их Хуралтай зөвшилцөхөд энэ зүйлийг нэгэн адил баримтална.

- 30 дугаар зүйл.Гадаад улсыг хүлээн зөвшөөрөх,
түүнтэй дипломат харилцаа тогтоох,
цуцлах тухай асуудлыг хянан хэлэлцэх

1.Гадаад улсыг хүлээн зөвшөөрөх тухай Засгийн газраас өргөн мэдүүлсэн асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ чуулганы хуралданаар хэлэлцүүлнэ.

2.Гадаад улстай дипломат харилцаа шинээр буюу сэргээн тогтоох тухай Засгийн газраас өргөн мэдүүлсэн асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо урьдчилан хэлэлцэнэ. Байнгын хороо уг асуудлыг сайшаан зөвшөөрч тухайн улстай тодорхой тохиролцоохыг Засгийн газарт үүрэг болгоно.Засгийн газар тухайн улстай тодорхой гохиролцсоны дараа уг асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо захир хэлэлцэж санал,дүгнэлтээ чуулганы хуралдаанаар хэлэлцүүлнэ.

3.Гадаад улстай дипломат харилцаагаа цуцлах тухай Засгийн газраас өргөн мэдүүлсэн асуудлыг зөвхө Байнгын хороо урьдчилан

хэлэлцэж санал, дүгнэлтээ чуулганы хуралдаанаар хэлэлцүүлнэ.

**31 дүгээр зүйл. Ерөнхийлөгч Улсын Их Хуралд
ажлаа хариуцах**

1. Монгол Улсын Үндсэн хуулийн гучин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Ерөнхийлөгч Улсын Их Хуралд ажлаа хариуцна.

2. Ерөнхийлөгч ажлын тайлангаа жил бүр Улсын Их Хуралд ирүүлнэ. Ерөнхийлөгч тайлангаа Улсын Их Хурлын чуулганд уншин сонгох бөгөөд тайлантай холбогдуулж Улсын Их Хурлын гишүүд асуулт тавьж болно.

/Энэ хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьсан тул уг хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэтгэл хуулийн энэ заалт хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөхгүй болно./

**32 дугаар зүйл. Улсын төвлөрсөн төсвийн
төслийг хэлэлцэж, батлах**

1. Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн улсын төвлөрсөн төсвийн төслийг Байнгын хороод эрхэлсэн асуудлынхаа хүрээнд салбарын төсвийн төслийн талаар нарийвчилсан задаргаа, мэдээ, судалгаа,

тооцоо гаргуулан авч хянана. Шаардлагатай бол ажлын хэсэг байгуулан ажиллуулж, Байнгын хорооны санал, дүгнэлтийг бэлтгэнэ.

2. Чуулганы хуралдаанаар улсын төвлөрсөн төсвийн төслийг 4 үе шаттайгаар хэлэлцэж батална.

Нэг дэх хэлэлцүүдгээр улсын төвлөрсөн төсвийн төслийг хэлэлцэх үед Засгийн газрын гишүүд, төсвийн ерөнхийлөн захирагчид, төвлөрүүлэн захирагчдыг байлцуулан асуулт, хариулт явуулж, санал, шүүмжлэл гаргана. Төсвийн төслийн талаар гишүүд үг хэлж, санал гаргасны дараа төслийг зохих Байнгын хороонд шилжүүлнэ.

Хоёр дахь хэлэлцүүдгээр Улсын Их Хурлын бүх Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо санал, дүгнэлтээ, Улсын Их Хурлын гишүүд тусгай саналтай бол түүнийгээ бичгээр Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын байнгын хороонд урьдчилан ирүүлнэ. Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын байнгын хороо эдгээр саналыг нягтлан үзэж дүгнэлтээ тусгана.

Улсын Их Хурлын Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, Төсвийн зарлагын дэд хорооны дүгнэлт, Улсын Их Хурлын гишүүний гаргасан тусгай саналыг Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын байнгын хорооны дүгнэлтийн хамт чуулганы хуралдаанд сонгоно. Санал, дүгнэлтийг сонссоны дараа гишүүд үг хэлж болно.

Гаргасан саналын дагуу санал хураалт явуулж, улсын төвлөрсөн төсвийн төслийг гурав дахь хэлэлцүүдгээ бэлтгүүлэхээр зохих Байнгын хороонд шилжүүлнэ.

Гурав дахь хэлэлцүүлгээр Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын байнгын хороо хоёрдугаар хэлэлцүүлгээр төсөлд орсон өөрчлөлтүүдийг тусгаж, танилцуулгын хамт чуулганы хуралдаанд оруулна. Хоёр дахь хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэртэсэн асуудлаар Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын байнгын хорооны саналаар чуулганы хуралдаанаар дахин санал хурааж болно.

Дөрөв дэх хэлэлцүүлгээр Улсын төвлөрсөн төсвийн тухай хуулийн төслийг зүйл, заалт бүрээр хэлэлцэж батална.

Монгол Улсын тухайн жилийн төвлөрсөн төсвийн тухай хуулийн эцсийн найруулгыг Улсын Их Хурал сонсоно.

3. Улсын төвлөрсөн төсвийн төсөлд тодотгол хийх асуудлыг энэ зүйлд заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэртэнэ.

4. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр шаардсан асуудлыг хэлэлцэхдээ энэ зүйлд заасан журмын дагуу хэлэлцэж болно.

33 дугаар зүйл. Улсын Их Хурлын хуралдааны үед
хэрэгжих хяналт

Улсын Их Хурал хуралдаанаахад үед хяналтаа дараахь хэлбэрээр хэрэгжүүлнэ:

—1/Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа хариуцан гайлагнадаг бусад байгууллагын илтгэл, мэдээлэл сонсох.

—2/Засгийн газарт асуулт тавих.

3/Засгийн газарт асуулт тавьж хариу авах.

4/ажлын хэсэг байгуулах, түүний ажлын дунг сонсох.

34 дүгээр зүйл. Засгийн газрын мэдээлэл сонсох, Засгийн газарт асуулт тавьж, хариу авах

1. Долоо хоногийн Баасан гариг бүрийн 16.40 цагаас 18.00 цаг хүртэл Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар Засгийн газрын мэдээлэл, Засгийн газарт тавьсан асуулт, асуултын хариуг сонсоно.

Засгийн газрын мэдээлэл хийх хугацаа 15 минутаас илүүгүй байна. Мэдээлэлтэй холбогдуулж Улсын Их Хурлын гишүүд асуулт тавьж, хариулт авч болно.

Асуулт, хариултын үргэлжлэх нийт хугацааг хуралдаан даргалагч тогтооно.

2. Засгийн газарт тавьсан асуулт гэдэг нь тодорхой нэг асуудлын талаар мэдээлэл авах зорилгоор Улсын Их Хурлын гишүүнээс Засгийн газарт, эсхүл Засгийн газрын аль нэг гишүүнд амаар болон бичгээр хандсаныг хэлнэ.

3. Улсын Их Хурлын гишүүн асуултын хариуг чуулганы хуралдаанд сонсох эсэх, хэзээ сонсох тухай саналаа Улсын Их Хурлын даргал ирүүлнэ.

4. Засгийн газар, түүний гишүүн асуултын хариуг 14 хоногийн дотор өгнө. Асуултын хариуг Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын аль нэг гишүүн чуулганы хуралдаанд сонгоно.

5. Бичгээр тавьсан асуултын хариу 5 минутаас илүүгүй байна

6. Асуулт тавьсан Улсын Их Хурлын гишүүд хуралдаан даргалагчийн зөвшөөрсний дагуу тавьсан асуулттайгаа нэг сэдэвтэй, ойролцоо, нжил асуултыг чуулганы хуралдаан дээр тодруулан тавьж болно.

35 дугаар зүйл. Засгийн газарт асуулга тавих

1. Засгийн газарт тавьсан/асуулга гэдэг нь Улсын Их Хурлын нэг буюу хэд хэдэн гишүүн нийлж, эсхүл Байнгын болон бусад хороо, нам, эвслийн бүлгээс улс орны нийтлэг эрх ашгийг хөндсөн болон бүрэн эрхэд нь хамаарах бусад асуудлаар Засгийн газрын бодлого, байр суурийг тодруулах, тодорхой үйл ажиллагаа явуулахыг шаардаж Засгийн газарт бичгээр ханасаныг хэлнэ.

2. Асуулга нь Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд нийцсэн байна.

3. Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хороо, нам, эвслийн бүлэг асуултынхаа хариуг хэзээ сонсох талаархи саналаа Улсын Их Хурлын даргад ирүүлднэ.

4. Засгийн газар асуултын хариуг 30 хоногийн дотор бичгээр өгөх бөгөөд Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүн асуултын хариуг чуулганы хуралдаанд сонгоно. Асуултын хариулт 15 минутаас илүүгүй байна.

5. Асуултын хариутай холбогдуулж Улсын Их Хурлын гишүүд тухайн сэдвээр тодруулан асууж болно.

6. Асуулга тавьсантай холбогдуулан Улсын Их Хурлаас зохих шийдвэр гаргах шаардлагатай гэж үзвэл уг асуудлыг холбогдох Байнгын хороонд тавина.

36 дугаар зүйл. Ажлын хэсэг байгуулж,
хяналтыг хэргижүүлэх

1. Улсын Их Хурал тодорхой албан тушаалтан, байгууллага эсхүл тодорхой асуудлын талаар баримт нотолгоо бүрдүүтэх, мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах, санал дүгнэлт бэлдүүлж, Улсын Их Хуралд хэлтэлцүүлэх зорилгоор ажлын хэсгийг байгуулж болно.

2. Ажлын хэсгийг Улсын Их Хурлын дарга өөрийн саналчилгаар, эсхүл зохих Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан саналын дагуу захирамжаараа байгуулна.

3. Улсын Их Хурлын даргын захирамжинд ажлын хэсэгт орох Улсын Их Хурлын гишүүдийн нэрс, ажлын үр дүнг танилцуулах хугацааг заана.

4.Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурал дахь олонхи, цөөнхийн нам, эвслийн бүлгийн аль алины нь төлөөлөл байвал зохино.

5.Ажлын хэсэг дараахь бүрэн эрхтэй:

1/тухайн байгууллагын эрх баригчдыг дуудан ирүүлэх, тэдний мэдээллийг сонсох, асуулт тавьж, хариулт авах, судалгаа тайлан, дүгнэлт бусад мэдээллийг гаргуулан авах эрхтэй;

2/хяналтын явцад олж авсан төрийн нууцыг хадгалах, шаардлагатай гэж үзвэл дүнг Улсын Их Хурлын хяналттай хуралдаанд хэлэлцүүлэх санал гаргах.

6.Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг зөвшөөрөөгүй ажлын хэсгийн гишүүн тусдаа дүгнэлт гаргаж болно. Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн зохих Байнгын хороо саналаа чуулганы хуралдаанд оруулна. Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд гишүүд асуулт тавьж, санал, дүгнэлт гаргаж болно. Шаардлагатай бол чуулганы хуралдаанаар ажлын хэсэг, Байнгын хорооны санал дүгнэлтийн талаар санал хураалгаж, Улсын Их Хурал зохих шийдвэр гаргана.

7.Ажлын хэсгийн хяналтын явцад тухайн асуудлыг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх байгууллагаас шалгаж эхэлсэн бол Улсын Их Хурлын хяналт хэрэгжүүлэх ажлын хэсэг үйл ажиллагаагаа даруй зогсооно.

ДӨРӨВДҮГЭЭГ БҮЛЭГ

Төсөл хэлэлцэх

37 дугаар зүйл. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл өргөн мэдүүлэх

1.Хууль санаачлагч хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг /цаашид "төсөл" гэх/ Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлнэ. Хууль санаачлагч шаардлагатай бол өргөн мэдүүлсэн төслийнхөө хамт түүнийг хэрэгжүүлэх хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл баталсан тохиолдолд бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хавсаргасан байна.

2.Өргөн мэдүүлсэн төслийг Улсын Их Хурлын дарга түүний агуулгыг үндэслэн тухайн асуудлыг эрхэлсэн зохих Байнгын хороонд шилжүүлнэ.

38 дугаар зүйл.Төсөл хэлэлцэх,
батлах үе шат

1.Улсын Их Хурлын төсөл хэлэлцэх, батлах үйл ажиллагаа дараахь үе шаттай хэрэгжинэ.

Нэгдүгээр үе шат:

1/нам, эвслийн бүлэг, зохих Байнгын хорооны хуралдаанаар төслийг чуулганаар хэлэлцэх эсэх тухай дүгнэлт гаргах;

2/Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар төслийг хэлэлцэх эсэх тухай санал хураалт явуулах.

Хоёрдугаар үе шат:

1/нам, эвслийн бүлэг, Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;

2/Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлэг явуулах;

Гуравдугаар үе шат:

1/анхны хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн асуудлыг тусгаж төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх;

2/Улсын Их Хурлын чуулганаар төслийн эцсийн хэлэлцүүлэг хийх;

3/төслийг батлах.

Дөрөвдүгээр үе шат:

1/эцсийн хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн асуудлыг тусгаж хууль, тогтоолын төслийн эцсийн найруулгыг бэлтгэх;

2/Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцах;

3/шийдвэрийг ёсчлох;

4/Ерөнхийлөгч Улсын Их Хурлын шийдвэрт хориг тавьсан бол тухайн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх.

2.Төсөл хянан хэлэлцэх явцад Улсын Их Хурал, эсхүл түүний Байнгын хороо ажлын хэсэг байгуулж болно.

39 дүгээр зүйл.Байнгын хороогоор төсөл

урьдчилан хэлэлцэх

1.Төслийг зохих Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх бөгөөд Улсын Их Хурлын гишүүн харьяалагдах Байнгын хорооны хуралд таслах эрхтэй, бусад Байнгын хорооны хуралд таслах эрхгүйгээр оролцоно.Байнгын хорооны хуралд Улсын Их Хурлын гишүүн санал, дүгнэлт гаргах, саналаа хураалгах, тухайн асуудлаар цөөнх болж зарчмын зөрүүтэй саналд Байнгын хорооны дүгнэлтэд тусгуулах эрхтэй.

Байнгын хорооны хуралдаанд тухайн төслийн талаар хууль санаачлагчид асуулт тавьж, хариулт авч болно.Асуулт, хариулт үргэлжлэх хугацааг хуралдаан даргалагч тогтооно.

Хэрэв уг төслийг баталснаар тухайн санхүүгийн жилийн улсын төсвийн зарлагын хэмжээ нэмэгдэхээр байвал энэ тухай Засгийн газрын санал, дүгнэлтийг заавал сонсоно.

2. Байнгын хорооны хуралдааныг тухайн Байнгын хорооны дарга даргалах бөгөөд хуралдаанд зөвхөн тухайн Байнгын хорооны гишүүн таслах эрхтэй оролцоно. Төслийн талаар бусад Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг зохих Байнгын хороо санал, дүгнэлтдээ хамтатган тусгана.

Төсөл хэлэлцэхэд биечлэн оролцох боломжгүй Улсын Их Хурлын гишүүн санал дүгнэлтээ зохих Байнгын хороонд бичгээр урьдчилан гаргаж болох бөгөөд түүнийг Байнгын хорооны хуралдаанд мавалт танилцуулж хэлэлцүүлнэ.

3. Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийн талаар санал хураалт явуулсны үндсэн дээр уг төслийг чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлагатай эсэх талаар дүгнэлт гаргаж, түүнийг чуулганы хуралдаанд илтгэх гишүүнийг томилно.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд хэлэлцэхээр шийдвэрлэсэн төслийг Байнгын хороо анхны хэлэлцүүлэгт бэлтгэн, төслийн талаар санал, дүгнэлт гаргаж, түүнийг чуулганы хуралдаанд илтгэх гишүүнийг томилно.

Байнгын хороо төслийг чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн дүгнэлтээ, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн санал, дүгнэлттэй хамтатган гаргаж болно.

4. Төслийг зохих Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хэлэлцэж болох бөгөөд нэгдсэн дүгнэлт гаргаж болно. Байнгын хороодын хамтарсан хуралдааны иршийг тус хороодын нийт гишүүний дийлэнх олонхи нь ирснээр хүчин төгөлдөрт тооцож, асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргавал Байнгын хороодын дарга нэр хамтран гарын үсэг зурж бичилно.

5. Хэрэв нэг асуудлаар хоёр буюу түүнээс дээш төсөл байгаа бол хууль санаачлагчийн зөвшөөрснөөр зохих Байнгын хороо тэдгэрийг нэгтгэн зохицуулж, нэг төсөл болгон чуулганы хуралдаанд хэлэлцүүлж болно.

Хэд хэдэн төслийг нэгтгэхийг хууль санаачлагч зөвшөөрөөгүй бол Байнгын хороо тэдгээр төслийн талаар нэгбүрчлэн энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу дүгнэлт гаргана.

Хууль санаачлагчийн зөвшөөрөлгүйгээр төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулж болохгүй.

6. Хууль санаачлагч, зохих Байнгын хороо болон бусад Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналаар зөвшилцөлд хүрэхийн тулд шинжлэх томилон дүгнэлт гаргуулах, Засгийн газрын холбогдох гишүүний болон бусад албан тушаалтны санал сонсох зэргээр ажиллаж болно.

**40 дүгээр зүйл. Улсын Их Хурлын чуулганы
хуралдаанаар төсөл хэлэлцэх**

1. Улсын Их Хурал Үндсэн хуулийн хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хууль санаачлагчаас өргөн мэдүүлж, чуулганы хуралдаанаар хэлэлцэхээр шийдвэрлэж, хэлэлцэх асуудлын төлөөлөгчөөнд оруулан баталсан төслийг хэлэлцэнэ.

Ерөнхийлөгчийн хориг, Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд хандаж гаргасан илтгэлт, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын ажлын дүн, тайлан сонсох, түүний удирдлагыг томилох, чөлөөлөх, Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлахаас бусад асуудлаар чуулганы хуралдааны хэлэлцэх асуудлын төлөөлөгчөөнд ороогүй төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр тухайн чуулганы явцад өргөн мэдүүлбэл Төрийн байгуулалтын байнгын хороо, зохих Байнгын хорооны санал, дүгнэлтийг харгалзан түүнийг чуулганаар хэлэлцэх эсэхийг чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ.

2. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг чуулганы хуралдаанаар хэлэлцэх эсхүл буцаах асуудлыг шийдвэрлэхдээ:

1/төслийн талаар хууль санаачлагчийн илтгэлийг сонсоно. Илтгэлтэй холбогдууж гишүүд асуулт асууж, хариулт авч болно,

2/Байнгын хороо, нам, ээслийн бүлгийн дүгнэлтийг сонсоно;

3/төслийг чуулганы хуралдаанаар хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулна;

4/хэрэв 39 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу хэд хэдэн төслийн талаар Байнгын хорооноос нэгбурчлэн дүгнэлт гаргасан бол аль төслийг нь сонгон анхны хэлэлцүүлэгт оруулах тухай санал хураалт явуулна.

Төслийг чуулганы хуралдаанаар хэлэлцэх шаардлагагүй гэж үзвэл төслийг буцаах тогтоол гаргана. Уг тогтоолд төслийг буцаах болсон үндэслэлийг заасан байвал зохинo.

3. Чуулганаар хэлэлцэхээр тогтсон төслийг дүгнэлт, холбогдох бусад баримт бичгийн хамт Улсын Их Хурлын гишүүдэд уг төсөл хэлэлцэж эхлэхээс долоо хоногийн өмнө зохих Байнгын хороо эрхлэн тараана. Төсөл олшруулах, тараах ажлыг Улсын Их Хурлын Тамгын газар /цаашид "Тамгын газар" гэх/ эрхэлнэ.

4. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулахдаа дараахь журмыг баримтална.

1/зохих Байнгын хорооны дүгнэлтийг танилцуулах хугацаа 15 минутаас илүүгүй байна. Дүгнэлтэд уг төслийн үзэл баримтлал төрийн бодлогод нийцэж байгаа эсэх, төсөл хууль тогтоомжийн бичлэгийн

техник хэл зүйн шаардлагыг хангасан эсэх болон төслийн зүйл, малтын талаар зарчмын өөр саналтай бол үндэслэл, шалтгааныг заана. Зохих Байнгын хороо төсөлд оруулах нэмэлт, өөрчлөлт болон Улсын Их Хурлын гишүүний зарчмын зөрүүтэй саналыг томъёолж бүх гишүүдэд тараасан байна;

2/Байнгын хорооны дүгнэлтийн дараа Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн дүгнэлтийг сонсоно. Дүгнэлтийг бүлгийн ахлагч, эсхүл гухайн асуудлыг хариуцаж буй бүлгийн аль нэг гишүүн танилцуулна.

Нам, эвслийн бүлгийн дүгнэлтийг танилцуулах хугацаа тус бүр 10 минутас илүүгүй байна.

Улсын Их Хурлын гишүүн хэлэлцэж байгаа асуудлаар үг хэлэх, гайлбар хийхдээ энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2-т заасан хугацааг баримтлах бөгөөд санал, дүгнэлтээ Байнгын хорооны болон нам, эвслийн бүлгийн дүгнэлтэд тусгуулж урьдчилан тараасан байна;

3/төслийн талаар гарсан зарчмын зөрүүтэй санал гэдэгт:

а/Байнгын хорооноос санал нэгтэй буюу олонхийн саналаар оруулахаар шийдвэртэсэн төсөлд тусгалдаагүй санал;

б/зохих Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж зөвшилцөлд хүрээгүй Улсын Их Хурлын гишүүний санал;

в/Улсын Их Хурал дахь олонхи, цөөнхийн нам, эвслийн бүлгээс зарчмын гэж үзэж дүгнэлтдээ тусгасан саналыг ойлгоно.

Зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүд уг саналынхаа талаар тайлбар хэлж болох бөгөөд түүнийг дэмжсэн болон эсрэг саналтай тус бүр нэг гишүүн үг хэлж болно;

4/Улсын Их Хурлын гишүүн Байнгын хорооны дүгнэлтэд тусгуулсан зарчмын зөрүүтэй саналаа бичгээр томъёолж урьдчилан өгсөн байна. Харин найруулгын чанартай засварыг ажлын хэсэгт өгнө.

Зарчмын зөрүүтэй саналуудыг нэгтгэж хуралдаан даргалагчид бүлтгэн өгөх асуудлыг Тамгын газар хариуцна;

5/хуралдаан даргалагч зарчмын зөрүүтэй асуудал бүрээр санал хураалгана.Тэгэхдээ зарчмын зөрүүтэй асуудлыг ямар хувилбараар шийдвэртэх саналтай байгаа, эсхүл уг асуудлаарх төслийн малтыг дахин гүйцээн боловсруулж саналыг сонсохын аль нэгээр хэлэлцүүтж гишүүдийн олонхийн саналаар шийдвэртэнэ;

6/хэрэв Ерөнхийлөгч хэлэлцэж байгаа төсөлтэй холбогдуулан Улсын Их Хуралд илгээлт, санал ирүүлсэн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүдэд урьдчилан тарааж танилцуулсан байна.

Хуралдаан даргалагч зарчмын зөрүүтэй асуудлаар санал хураалгахдаа санал хураах цагийг тогтоож, нийт гишүүдэд зарлаж

болно. Хэрэв санал хураах цагийг товлон зарласан бол Улсын Их Хурлын гишүүн өөрийн биеэр хүрэлцэн ирж санал хураалтад оролцоно;

5. Улсын Их Хурлын гишүүн нь зөвхөн хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой горимын санал гаргах хүсэлт тавьж болно. Хуралдаан даргалагч горимын саналыг сонсож, шаардлагатай бол түүгээр санал хураалтана.

6. Зарчмын зөрүүтэй асуудлаар санал хураасны дараа дараахь шийдвэрийн аль нэгийг санал хурааж шийдвэртэнэ:

— а/төслийг бүхэлд нь эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх;

— б/төслийг хууль санаачлагчид буцаах.

7. Анхны хэлэлцүүлгийн явцад төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй түүнчлэн уг төслийг батлах санал гарсан бол түүний эцсийн хэлэлцүүлгийг шууд явуулж болно.

8. Улсын Их Хурал төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр зохих Байнгын хороонд шилжүүлэхдээ дэмжигдсэн саналын дагуу төслийг зарчмын хувьд өөрчлөх, найруулах үүрэг бүхий Улсын Их Хурлын болон хууль санаачлагчийн хамтарсан ажлын хэсэг байгуулж болно.

9. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэж, хэлэлцүүлэхээр оруулах хугацааг төсөл боловсруулах ажлын хэмжээ, шаардлагыг харгалзан хуралдаан даргалагч тогтооно.

10. Анхны хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн асуудлыг төсөлд тусгаж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх ажлыг дараахь үе шаттай хэрэгжүүлдэг:

1/төслийг хууль санаачлагч, зохих Байнгын хороо хариуцаж ажлын хэсэгт эцэслэн боловсруулна;

2/төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэн дүгнэлт гаргасан зохих Байнгын хороо анхны хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн байдлыг үндэслэн Улсын Их Хурлын гишүүний болон хууль санаачлагчийн төмбөөлж өгсөн санал бүрийг хянан үзэж төсөлд зохих нэмэлт өөрчлөлт оруулж, хууль тогтоомжийн бичлэгийн техник, хэл зүй, найруулгын талаас нь нягтлан зохих танилцуулга бэлтгэнэ.

11. Төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулахдаа дараахь журмыг баримтална:

1/төслийн талаар зохих Байнгын хорооны танилцуулга хийх хугацаа 10 минутаас илүүгүй байна;

2/зохих Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт, хариулт явуулж болно;

3/эцсийн хэлэлцүүлгийн явцад дараахь асуудлаар санал хурааж болно:

а/эхний хэлэлцүүлгийн үед гүйцээн боловсруулахаар шийдвэрлэсэн төслийн зүйл, заалт байгаа бол;

б/эхний хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн боловч уг асуудлаар дахин санал хураах шаардлагатай гэсэн зохих Байнгын хорооны саналыг чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны нэг нь дэмжсэн бол;

в/төслийн аль нэг зүйл, заалт хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа хууль болон уг төслийн бусад зүйл, заалттай зөрчилдөж байна гэж зохих Байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороо үзсэн бол дээрх асуудал тус бүрээр санал хурааж шийдвэрлэнэ.

4/санал хураалгахын өмнө тухайн саналыг гаргасан Улсын Их Хурлын гишүүн, тайлбар өгөх буюу үг хэлж болно.Тайлбар өгч, үг хэлсэн хүмүүстэй ижил тооны гишүүд хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр дээрх саналын эсрэг үг хэлж болно.

5/эцсийн хэлэлцүүлэг дууссаны дараа төслийг бүхэлд нь батална. Төслийг бүхэлд нь батлах санал хураалтын цагийг хуралдаан даргалагч товлон зарлаж болно.

Хэрэв төслийг бүхэлд нь батлаагүй бол төслийг хууль санаачлагчид буцаана.

12.Шаардлагатай гэж үзвэл эцсийн хэлэлцүүлгээр баталсан хуультай холбогдсон тогтоолын төслийг хэлэлцэн батална;

13.Эцсийн хэлэлцүүлгээр баталсан төслийн эцсийн найруулгыг хэлэлцүүлэг дууссанаас хойш ажлын 6 өдөрт багтаан Улсын Их Хуралд танилцуулна. Эцсийн найруулгыг танилцуулах ажлыг Ерөнхий нарийн бичгийн дарга хариуцна.

41 дүгээр зүйл.Санал хураалт, түүнийг явуулах журам

1.Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд төслийн талаар санал хураалт явуулахдаа Байнгын хорооны гишүүдийн олонхи нь дэмжсэн зарчмын зөрүүтэй саналыг уг саналын томъёоллоор, харин Байнгын хорооноос олонхийн дэмжлэг аваагүй саналыг төслийн томъёоллоор санал хураалтна.

Байнгын хорооны хуралдаанд санал хураалт явуулахдаа төслийн томъёоллоор санал хураалт явуулна. Энэ тохиолдолд нам, эвслийн бүлэг, Улсын Их Хурлын гишүүний гаргасан санал хажуутгийн саналд тооцогдоно.

2.Байнгын хорооны хуралдаанаар тухайн асуудлаар санал хураалт явуулсны дараа цөөнх болсон, эсхүл цөөнхийг төлөөлсөн 3 хүртэл гишүүн тайлбар хэлж болно.Хэрэв цөөнх дахин санал хураалгахыг хүсвэл төслийн томъёоллоор дахин санал хураалт явуулна.

Эхний 2 санал хуралтад нэг томъёолол 2 удаа олонхийн дэмжлэг авсан бол уг томъёоллыг баталсанд тооцно.

Хэрэв эхний санал хуралтад олонхийн дэмжлэг авсан томъёолол 2 дахь санал хуралтад олонхийн дэмжлэг авч чадаагүй бол 2 дахь санал хуралтад цөөнх болсон, эсхүл цөөнхийг төлөөлсөн 3 хүртэл гишүүн тайлбар хэлж болно.

Хэрэв цөөнх дахин санал хураалгахыг хүсвэл төслийн томъёоллоор дахин нэг удаа санал хураалт явуулж олонхийн санал авсан томъёоллыг баталсанд тооцно.

3. Санал тэнцвэл дахин нэг удаа санал хураалгана. Хэрэв санал дахин тэнцвэл хуралдаан даргалагч хоёр талаас тус бүр нэг гишүүний тайлбарыг сонсоно. Санал дахин тэнцвэл хэрхэхийг хуралдаан даргалагч шийднэ.

4. Үндсэн хууль, энэ хууль болон, бусад хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд санал хураалт явуулахдаа хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар уг асуудлыг шийдвэрлэнэ.

Энэ хууль болон бусад хуульд нууц санал хураалт явуулж шийдвэрлэхээр зааснаас бусад тохиолдолд санал хураалтыг илээр явуулна. Ил санал хураалтыг гар өргөж, эсхүл цахим тоолуураар, харин нууц санал хураалтыг санал хураах хуудсаар, эсхүл цахим тоолуур ашиглан явуулна.

5. Улсын Их Хурлын гишүүн чуулганы тухайн одрийн хуралдаанд ирцээ бүртгүүлсэн бол хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд санал хураахад заввал оролцоно. Хуульд заасан журмын дагуу санал хурааж нэгэнт баталсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санал хураах үед байгаагүй гэсэн шалтгаанаар Улсын Их Хурлын гишүүн дахин хэлэлцүүлэх эрх эдлэхгүй.

6. Улсын Их Хурлын гишүүн зөвхөн "зөвшөөрсөн", "тагталзан" гэсэн 2 саналын аль нэгийг огно. Хуралдаанд оролцож байгаа боловч санал өгөхгүй байгаа гишүүнийг тагталзаж байгаад тооцно.

7. Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн тухайн санал хураалгаж буй асуудлаар нэрээр нэг удаа санал огно.

42- дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүн санал хураалтанд таслах эрхтэй оролцохгүй байх

Улсын Их Хурлын гишүүн дараахь тохиолдолд санал хураалтанд таслах эрхтэй оролцохгүй:

1/өөрийг нь Улсын Их Хурлын дарга, дэд даргад нэр дэвшүүлж, сонгох санал хураалт;

2/өөрийнх нь харьяалагдаагүй, зөвлөх эрхтэй оролцож байгаа Байнгын хорооны хуралдааны санал хураалт ;

3/өөрийнх нь бүрэн эрхийг түдгэлзүүлэх, гишүүнээс чөлөөлөх, эгүүлэн татах эсэх асуудлаар санал хураалт;

4/өөрийг нь гэмт хэрэгт холбогдсон эсэх асуудлыг шалгах зөвшөөрлийг эрх бүхий байгууллагад олгох талаархи санал хураалт;

5/холбогдох байгууллагад өөрийг нь сэжигтнээр албадан саатуулах, сэжигтнээр болон ял сонгосны дараа цагдан хорих, өөрт нь шүүхийн журмаар захиргалны шийтгэл ногдуулах, гэр, албан ороо, биед нь нэгжлэг хийхийг зөвшөөрөх эсэх асуудлаар явуулах санал хураалт.

**43 дүгээр зүйл. Улсын Их Хурлын шийдвэрийг
ёсчлөх**

1. Улсын Их Хурал хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулгатай танилцсанаас хойш ажлын 3 өдрийн дотор Улсын Их Хурлын дарга уг шийдвэрт гарын үсэг дурж ёсчилно.

2. Улсын Их Хурлын шийдвэрийг ёсчилсноос хойш 24 цагийн дотор Ерөнхийлөгчид илгээнэ.

**44 дүгээр зүйл. Улсын Их Хурлын шийдвэр
хүчин төгөлдөр болох**

1. Улсын Их Хурал өөр хутагтаа тогтоогоогүй бол шийдвэрийг ёсчилж илгээснээс хойш Ерөнхийлөгч ажлын 5 өдөрт багтаан тухайн хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавьсан бол түүнийг хэлэлцэх асуудлын дараалал харгалзахгүйгээр тэргүүн ээлжинд хэлэлцэж чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёр нь хоригийг хүлээн зөвшөөрөөгүй бол Улсын Их Хурлын тухайн шийдвэр хэвээр үлдэнэ.

2. Ерөнхийлөгч Улсын Их Хурлын чуулган ажлаа дууссаны дараа Улсын Их Хурлын шийдвэрт хориг тавьсан бол Улсын Их Хурал ээлжит бус чуулганаар хэлэлцэн шийдвэрлэж болно. Ерөнхийлөгчийн хоригийг Улсын Их Хурлын ээлжит бус чуулганаар хэлэлцэн шийдвэрлээгүй бол дараагийн ээлжит чуулганаар эхний ээлжинд хэлэлцэн шийдвэрлэнэ.

3. Улс оронд онцгой нөхцөл байдал бий болсон, эсхүл Улсын Их Хурлын чуулганы ажиллагаа өндөрлөх гэж байгааг харгалзан Ерөнхийлөгчийн хориг тавих хутаглааг Улсын Их Хурал тогтоон өгч болно.

4. Улсын Их Хурлын тухайн шийдвэрт өөрөөр заагаагүй бол уг шийдвэр албан ёсоор нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

**45 дугаар зүйл. Улсын Их Хурлын шийдвэрийг
нийтлэх, мэдээлэх**

1.Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг баталснаас хойш Ерөнхий нарийн бичгийн даргын зөвшөөрснөөр төрийн төв хэвлэлд албан ёсоор нийтэлж, хэвлэл, мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

2.Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг төв, орон нутгийн бусад сонин хэвлэлд нийтлэх, радио, телевизээр дамжуулахдаг төрийн төв хэвлэлд нийтэлсэн албан ёсны эхийг баримтлах бөгөөд ийнхүү дамжуулан нийтэлснийг албан ёсны бус гэж үзнэ.

3.Улсын Их Хурлын чуулганы явцын тухай олон нийтэд сонордуулах албан ёсны мэдээллийг зөвхөн Тамгын газар хариуцан нийтлүүлдэг.

4.Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тэмдэглэлийг Улсын Их Хурлын номын сан, Улсын төв болон аймаг, нийслэл дэх төв буюу төвлөрсөн номын санд тавина.

**46 дугаар зүйл. "Төрийн мэдээлэл"
эмхтгэл**

1."Төрийн мэдээлэл" эмхтгэл нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, хуулийн талаархи Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбарыг бүрэн эхээр нь эмхтгэн нийтлэх төрийн албан ёсны хэвлэл мөн. Энэхүү эмхтгэлийг Тамгын газраас эрхлэн сар тутам гаргана.

2."Төрийн мэдээлэл" эмхтгэлийн эрхлэгч нь Ерөнхий нарийн бичгийн дарга байна.

3."Төрийн мэдээлэл" эмхтгэлийг Засгийн газрын хэвлэх үйлдвэрт тогтмол хэвлэн гаргана.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

**47 дугаар зүйл. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны
тэмдэглэл хөтлөх, түүнийг ашиглах,
хадгалах**

1.Улсын Их Хурлын чуулганы хуралдаан, Улсын Их Хурлын гишүүдийн ажлын зөвлөлгөөн, Байнгын хорооны хуралдааны явцыг албан ёсоор дэс дараалан тэмдэглэн авах, уг тэмдэглэлийг ашиглах, хадгалах ажлыг Ерөнхий нарийн бичгийн даргын тогтоосон журмын дагуу Тамгын газар эрхлэн гүйцэтгэнэ.

2. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны явцын тэмдэглэлийг гараар болон соронзон хальсанд нэгэн зэрэг бичнэ. Шаардлагатай гэж үзвэл хуралдааны явцын талаар дуутай дүрс бичлэг хийж хадгална.

3. Хуралдааны явцын тэмдэглэлд дараахь баримт бичгийг заавал хавсаргана:

1/тухайн өдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, урилгаар оролцсон болон байлцсан хүмүүсийн нэр, албан тушаал;

2/хуралдаанаар хэлэлцсэн хууль, бусад шийдвэрийн төсөл /хувилбарууд/ тэдгээрийн танилцуулга, дүгнэлт, санал;

3/хэлэлцэж байгаа асуудлаар Улсын Их Хурлын гишүүнээс бусад гишүүдэд тараасан санал;

4/хуралдааны явцад Улсын Их Хурлын гишүүдэд сонордуулсан өргөх бичиг, мэдэгдэл, шахилгаан утас;

5/хуралдааны явцад хэлэлцсэн, сонордуулсан, тараасан бусад баримт бичиг;

6/гишүүн тусгайлан тэмдэглүүлэхээр өөрөө бичсэн зүйл.

4. Хуралдааны явцын тэмдэглэлийг гараар бичихдээ дараахь зүйлийг заавал тусгана:

1/хуралдаан эхэлсэн, завсарласан, дууссан болон асуудлыг хэлэлцэж эхэлсэн, дууссан он, сар, өдөр, цаг, минут;

2/кмр асуудал, хаанаас, хэн төлөөлж оруулсан тухай товч томъёолол;

3/хэлэлцэж байгаа асуудалтай холбогдсон асуулт, хариулт, гаргасан санал, шүүмжлэл, хэлсэн үг;

4/санал хураалтын дүн /тоо, хувиар/, хэрэв нэрээр санал хураавал Улсын Их Хурлын гишүүн нэг бүрийн нэр, өгсөн санал;

5/ирц /тоо, хувиар/, байхгүй гишүүний нэр, шалтгаан;

6/хуралдаанд хоцорч ирсэн, чөлөө авсан, өвчтэй байсан, тасалсан, хуралдааны даргын зөвшөөрөлгүй гарч явсан гишүүний нэр, цаг минут;

7/гишүүний тусгайлан тэмдэглүүлэхээр хэлсэн үг.

5. Гишүүний хуралдаанд хэлсэн үгийг тодорхой бичих бөгөөд тусгайлан тэмдэглүүлсэн зүйлийг тухайн гишүүнд хянуулж гарыг үсэг зуруулна.

6. Улсын Их Хурлын гишүүн хүсвэл өөрийн болон бусдын хэлсэн үгийн бичлэгтэй танилцаж болно.

7. Гаргасан шийдвэрийг төслийн хувилбарын хамт гар тэмдэглэлд хэлэлцсэн дарааллаар нь дугаарлан заавал хавсаргана.

8. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны явцын тэмдэглэлтэй Ерөнхий нарийн бичгийн дарга танилцаж гарын үсэг зурна.

48 дугаар зүйл.Хуралдааны явцын гар тэмдэглэл,
соронзон болон дуутай дүрс бичлэг
ашиглах, хадгалах

1.Хуралдааны явцын гар тэмдэглэл, соронзон бичлэгийг Улсын Их Хурлын чуулганы материал бэлтгэж хэвлүүдэх, хэвлэл, мэдээллийн байгууллагад лавлагаа өгөх, мэргэантай асуудал шийдвэрлэхэд ашиглуулна.

2.Хуралдааны явцын гар тэмдэглэл, соронзон болон дуутай дүрс бичлэгийг Улсын Их Хурлын гишүүд, Ерөнхий нарийн бичгийн дарга, Тамгын газрын ажилтан шууд, бусад байгууллагын албан тушаалтанд Ерөнхий нарийн бичгийн даргын зөвшөөрлөөр үзүүлж, сонгоно.

3.Хуралдааны явцын гар тэмдэглэл, соронзон болон дуутай дүрс бичлэгийг Улсын Их Хурлын гишүүд болон Тамгын газрын ажилтнуудад 7 хоног хүртэлх хугацаагаар ашиглуулах бөгөөд зөвшөөрөлгүй олшруулах, хувилахыг хориглоно. Харин бусад байгууллагын албан тушаалтанд архивын ажилтны дэргэд үзүүлж, сонгоно.

4.Хуралдааны явцын гар тэмдэглэл, соронзон болон дуутай дүрс бичлэгийг Тамгын газрын архивт хадгална. Энэ тухай журмыг Ерөнхий нарийн бичгийн дарга тогтооно.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

/Жич: Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьсан тул уг хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэтгэл энэ хуулийн уг заалт нь хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөхгүй болохыг сонордуулья. Энэ тухай тайлбарыг хуулийн хориг тавигдсан заалтын ард мөн хийсэн болно./

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 2 дугаар
сарын 6-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурлын гишүүн /цаашид "Улсын Их Хурлын гишүүн" гэх/-ний бүрэн эрх, халдашгүй байдал, түүний бүрэн эрхийн баталгааг тогтоох, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж

Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох

1.Улсын Их Хурлын гишүүн бол төрийн эрх барих дээд байгууллагад сонгогдсон ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.

2.Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын 25 нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, сонгоно.

4 дүгээр зүйл.Улсын Их Хурлын гишүүн тангараг өргөх

Улсын Их Хурлын гишүүн төрийн сүлдэндээ "Монгол Улсын Их Хурлын гишүүн би ард түмнийхээ элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн, төрийн хуулийг дээдлэн сахиж, гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая" гэж тангараг өргөнө.

5 дугаар зүйл.Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаа

1.Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаа Үндсэн

хуулийн хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 4 жил байна.

2.Үндсэн хуулийн хорин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь Төрийн сүлдэндээ тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болно.

6 дугаар зүйл.Улсын Их Хурлын гишүүн хавсарч болохгүй ажил, албан тушаал

1.Улсын Их Хурлын гишүүн улс төрийн нам болон төрийн бус байгууллагад сонгуульт ажил, албан тушаал эрхлэх, сургалт, эрдэм шинжилгээний ажил хийхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.

Улсын Их Хурлын гишүүн ажил, албан тушаал хавсран эрхлэх нь Улсын Их Хурлын гишүүнийхээ үүрэгт ажлаа биелүүлэхэд нь саад болох үндэслэл болохгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж болохгүй бөгөөд өмнө нь хуулийн этгээдийн эрх бүхий аж ахуйн нэгж, тэдгээрийн нэгтгэлийн үйл ажиллагаа эрхэлдэг байсан бол уг ажлаа өөрийнхөө итгэмжилсэн хүнд шилжүүлэн хөтлүүлнэ.

3.Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд аж ахуй эрхлэгчдийн холбоонд элсэх, аж ахуйн нэгжийн төлөөлөн удирдах болон хяналтын зөвлөлд сонгогдон ажиллаж болохгүй бөгөөд өмнө нь эдгээр ажил, албан тушаал эрхэлж байсан бол уг сонгуульт ажлаас гарах, гишүүнчлэлээ түдгэлзүүлэх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

4.Улсын Их Хурлын гишүүн хуулиар хориглосон хавсарч үл болох ажил, албан тушаал эрхлэх асуудлыг гишүүний бүрэн эрхээ эхлэхээс өмнө шийдвэрлэсэн байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх

7 дугаар зүйл.Улсын Их Хурлын гишүүний үндсэн эрх

1.Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь үндсэн эрхтэй:

1/хууль санаачлах, тодорхой асуудал хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд саналаа өргөн мэдүүлэх;

2/санаачилсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслөө өөрийн саналаар эгүүлэн авах;

3/асуудал хэлэлцэн шийдвэрлэхэд чуулган, өөрөө гишүүн нь байгаа Байнгын болон дэд, түр хорооны хуралдаанд таслах эрхтэй оролцох;

4/Улсын Их Хурлын дарга, дэд дарга, Байнгын болон бусад хорооны дарга, Улсын Их Хурлын сонгуульт бусад удирдах тушаалд сонгогдох, тэдгээрт өөрийн нэрээ дэвшүүлэх;

5/Байнгын болон бусад хороо, Улсын Их Хурлын бусад байгууллагад саналаараа гишүүнээр орох, Улсын Их Хурлаас болон Байнгын хорооноос байгуулсан ажлын хэсэгт хүсэлтээрээ орж ажиллах;

6/хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт асуух, хариулт авах, санал, дүгнэлт гаргах;

7/зарчмын зөрүүтэй саналаа чуулганы хуралдаанд оруулах;

8/Улсын Их Хурлаас байгуулсан байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, мөн сонгох, томилох албан тушаалтны талаар санал гаргах, дүгнэлт хийх;

9/Улсын Их Хурлаас томилсон албан тушаалтны илтгэл, сонголт хэлэлцэх тухай болон тэдэнд үл итгэхээ илэрхийлж эгүүлэн татах, огцруулах тухай санал оруулах;

10/бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ аль ч байгууллагад чөлөөтэй нэвтэрч, хэнтэй ч хүлээгдэлгүйгээр уулзах, тухайн албан тушаалтан, ажилтанд асуулга, асуулт тавих, хуульд заасан хугацааны дотор хариуг нь авах;

11/Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлаас томилсон албан тушаалтанд асуулга тавьж, шаардлагатай гэж үзвэл тухайн асуудлаар Улсын Их Хурлын шийдвэр гаргуулах санал оруулах;

12/Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагаатай танилцах;

13/хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийн талаар холбогдох байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл шаардаж авах.

8 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүний үндсэн үүрэг

1. Улсын Их Хурлын гишүүн үйл ажиллагаагаа Улсын Их Хурлын өмнө хариуцна.

2. Улсын Их Хурлын гишүүн дараахь үндсэн үүрэгтэй:

1/үйл ажиллагаандаа нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлах;

2/Байнгын хороонд заавал ажиллах;

3/Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан, харьяалагдах Байнгын болон бусад хороодын хуралдаанд тогтмол оролцож, олонхийн саналаар шийдвэрлэсэн асуудлыг хүндэтгэн сахих;

4/Үндсэн хуулийн хорин долдугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын онцгой чуулганд дуудлага хүлээлгүйгээр нэн даруй хүрэлцэн ирэх;

5/сонгогчдоо төлөөлөх, тэдэнтэй тогтмол холбоотой ажиллах;

6/Улсын Их Хурлын чуулган, Байнгын болон бусад хорооны хуралдааны дэгийг сахих;

7/хууль болон Улсын Их Хурлын гишүүний нэр төрд харш зүйл хийхгүй байх;

8/Улсын Их Хурлын гишүүний хувьд үг хэлэх, санал гаргах, дүгнэлт хийхдээ асуудалд нотолгоотой, хариуцлагатай хандах;

9/төрийн зүтгэлтний нийтлэг болон Улсын Их Хурлын гишүүний хувьд тогтоосон ёс зүйн хэм хэмжээг чанд сахих, төрийн нууц хадгалах;

10/эрхэлж байсан аж ахуй, өөрийн өмч, эзэмшилтэй нь холбоотойгоор орж ирсэн болон аливаа бусад орлогыг тогтоосон журмын дагуу үнэн зөв мэдүүлэх.

3.Улсын Их Хурлын гишүүн дотоод, гадаадын хөндлөнгийн этгээдээс албан үйл ажиллагаатай нь холбогдуулан өөрт нь өгсөн бэлгийн талаар Төрийн байгуулалтын байнгын хороонд тухай бүр мэдэгдэх үүрэгтэй.

4.Улсын Их Хурлын гишүүн өөрт нь өгсөн нэг сарын цалингийн хэмжээнээс дээш төгрөгийн үнэтэй бэлгийн зүйлсийг Улсын Их Хурлын Тамгын газарт өгөх бөгөөд тухайн зүйлсийн үнийн нэг сарын цалингийнхаа хэмжээнээс дээш төгрөгийн зөрүүг Улсын Их Хурлын төсөвт төлөх замаар өөртөө шилжүүлэн авч болно. Улсын Их Хурлын Тамгын газар Улсын Их Хурлын гишүүдийн тушаасан бэлгийн зүйлийг Улсын Их Хурлын даргын захирамжаар баталсан журмын дагуу зарцуулна.

5.Улсын Их Хурлын гишүүний орлогын мэдүүлгийг Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцан хадгална.

**9 дүгээр зүйл. Улсын Их Хурлын гишүүнд
хориглох үйл ажиллагаа**

Улсын Их Хурлын гишүүнд дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

1/Улсын Их Хурлын гишүүний зардлын төсвийг хэтрүүлэх, зориулалтын бусаар зарцуулах;

2/хуулийн төсөл, бусад асуудал боловсруулах, хэлэлцүүлэхтэй холбогдуулж бусдаас шан харамж авах;

3/ ашиг хонжоо олох зорилгоор төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, албаны мэдээллийг ашиглах;

4/ашиг хонжоо олох зорилготой аливаа үйл ажиллагаанд Улсын Их Хурлын гишүүний нэр, эрхийг ашиглах;

5/Улсын Их Хурлын гишүүний нэрээ буюу эрх мэдлээ ашиглан үнэт цаас, эд хөрөнгө олох давуу эрх эдлэх, бусдад давуу байдал олгох үйл ажиллагаа явуулах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн баталгаа

10 дугаар зүйл.Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн баталгаа

1.Улсын Их Хурлын гишүүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь төрийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтан бүх талын туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

2.Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь Улсын Их Хурлын Тамгын газрал мөргөжил, арга зүйн туслалцаа үзүүлж, техник, зохион байгуулалтын бүх талын нөхцөлөөр хангана.

3.Улсын Их Хурлын гишүүн бусдыг доромжлох, гүтгэхээс бусад тохиолдолд бүрэн эрхийнхээ хүрээнд хэлсэн үг, дэвшүүлсэн санал, өөрийн санаачилсан хууль, Улсын Их Хурлын бусад шийавэрийн төсөл, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан асуудлын төлөө бүрэн эрхийнхээ хугацаанд болон түүний дараа хуулийн хармуцлага хүлээхгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн гадаадад зорчих, байх хугацаандаа дипломат эрх, ямба, дархан эрх эдэлнэ.

5.Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд үнэмлэх, энгэрийн тэмдэг, албаны хэвлэмэл хуудас, нэрийн хуудас хэрэглэнэ. Тэдгээрийн загвар, хэрэглэх журмыг Улсын Их Хурлын даргын захирамжаар батална.

6.Улсын Их Хурлын гишүүний харилцуур утас болон бусад холбооны хэрэгсэл төрийн хамгаалалтад байх бөгөөд бүрэн эрхээ хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа явуулахтай холбогдсон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглоно.

7.Улсын Их Хурлын гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол холбогдох албан тушаалтан энэ тухай Улсын Их Хурлын даргад 24 цагийн дотор нэн даруй мэдэгдэнэ. Үүнгээс бусад тохиолдолд Улсын Их Хурлын гишүүнийг албадан саатуулах,

цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр, албан өрөө, биед нь нэгжлэг хийхийг хориглоно.

8. Улсын Их Хурлын гишүүний албан тушаалд ажилласан хугацааг мэргэжлээрээ ажилласан хугацаанд оруулан тооцно.

9. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон, Улсын Их Хурал өөрөө тарах шийдвэр гаргасан, Улсын Их Хурлын гишүүн биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлж өгөхийг хүсэж өргөдөл гаргасныг Улсын Их Хурал дэмжсэн тохиолдолд түүнийг гишүүнээр сонгогдохоос өмнөх ажилд нь эгүүлэн ажиллуулах буюу тухайн ажил байхгүй бол ажил эрхлэх хүртэлх 6 сарын хугацаанд Улсын Их Хурлын гишүүн байсан үеийн авч байсан цалингийн хэмжээнээс буурахааргүй тэтгэмж, хэрэв бага цалинтай ажил эрхэлж байгаа бол цалингийн зөрүүтэй тэнцэх хэмжээний тэтгэмж мөн хугацаанд олгоно. Хэрэв Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдохоос өмнө оршин сууж байсан газраа шилжвэл өөрийнх нь болон гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүний замын зардал, ачаа, тээшийн хөлсийг авто хөсгийн тарифаар тооцож олгоно.

**11 дүгээр зүйл. Улсын Их Хурлын гишүүний төсөв,
цалин, бусад хангамж**

1. Улсын Их Хурлын гишүүний төсөвт түүний төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд тохирсон цалин, унаа, албан томилго, бичиг хэргийн зардал, энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан цалингийн сан, бусад зардал багтана.

2. Улсын Их Хурлын гишүүний төсвийн хэмжээг түүний сонгогдсон тойргийн онцлогийг нь харгалзан Улсын Их Хурлаас харилцан адилгүй тогтоож болно.

3. Улсын Их Хурлын гишүүний цалин, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай бусад хангамжийг Улсын Их Хурал тогтооно.

4. Улсын Их Хурлын гишүүний орон сууцны талбайн хөлсний болон хувийн харилцуур утасны /үүрэн харилцуур утаснаас бусад/ төлбөрийн 50 хувь, төрийн төв хэвлэлийн захиалгын төлбөрийг улсын төсвөөс гаргана.

/Энэ хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьсан тул уг хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэтгэл хуулийн энэ заалт хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөхгүй болно./

5. Улсын Их Хурлын гишүүний төсвийг Улсын Их Хурлаас баталсан журмын дагуу Тамгын газар тухайн гишүүний зөвшөөрөлтэйгээр зарцуулна. Улсын Их Хурлын гишүүний төсвийн зарцуулалтад Төрийн байгуулалтын байнгын хороо хяналт тавина.

6. Улсын Их Хурлын гишүүний төсвийн цалингийн сангаас бусад зүйлийг хооронд нь шилжүүлэн зарцуулж болно.

7. Улсын Их Хурлын гишүүн нь төсвийн зарцуулалтын тухай мэдээллээ Улсын Их Хурлын Тамгын газраас хүссэн цагтаа авах эрхтэй.

**12 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүний орон тооны
ажилтан, бие төлөөлөгч-туслах**

1. Улсын Их Хурлын гишүүн орон тооны ажилтантай байж болно. Ажилтны цалингийн сан, бичиг хэргийн зардлыг Улсын Их Хурлын төсөвт тусгана.

2. Улсын Их Хурлын гишүүн сонгогдсон тойрогтоо бие төлөөлөгч-туслахтай байж болно. Бие төлөөлөгч-туслахын цалингийн сан, бичиг хэрэг, холбооны болон бусад зардлыг Улсын Их Хурлын гишүүний төсөвт тусгана. Улсын Их Хурлын гишүүн сонгогдсон тойргийнхоо онцлогийг харгалзан бие төлөөлөгч-туслахын цалингийн сан, бусад зардалд багтаан 2-оос дээшгүй бие төлөөлөгч-туслахтай байж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

**13 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг
нь түдгэлзүүлэх, түүнийг чөлөөлөх, эгүүлэн татах**

1. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх, түүнийг чөлөөлөх, эгүүлэн татах эсэх асуудлыг зөвхөн Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар шийдвэртэнэ.

2. Дараахь тохиолдолд Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг шийдвэртэнэ:

1/энэ хуулийн 10 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар баривчлагдсан;

2/эрх бүхий байгууллага Улсын Их Хурлын гишүүнд холбогдох эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд тухайн гишүүнийг сэжигтнээр цагдан хорих зөвшөөрөл олгохыг хүссэн;

3/эрх бүхий байгууллага Улсын Их Хурлын гишүүнд ял сонгосон бөгөөд түүнийг цагдан хорих зөвшөөрөл олгохыг хүссэн.

3. Дараахь тохиолдолд Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлын гишүүнийг чөлөөлнө:

1/Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон;

2/бисийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос чөлөөлж

өгөхийг хүсэж гишүүн өөрөө өргөдөл гаргасан.

4.Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй гэж Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргасан бол Төрийн байгуулалтын байнгын хорооны санал дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурал тухайн гишүүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

5.Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоосон бол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА**

Р.ГОНЧИГДОРЖ

/Жиг: Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьсан тул уг хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэтгэл энэ хуулийн уг заалт нь хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөхгүй болохыг сонордуулья. Энэ тухай тайлбарыг хуулийн хориг тавигдсан заалтад мөн хийсэн болно/

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 2 дугаар
сарын 6-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. "Монгол Улсын Их Хурлын тухай", "Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай", "Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай" хуулиудыг баталсантай холбогдуулан 1992 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн "Монгол Улсын Их Хурлын тухай" хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг "Монгол Улсын Их Хурлын тухай", "Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай", "Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай" хуулиуд хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА**

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 2 дугаар
сарын 6-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

I дүгээр зүйл. Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дараах заалтыг нэмсүгэй:

"Засгийн газар нь Улсын Их Хурлаас хуулиар тусгайлан эрх олгосон нөхцөлд хуульд нийцүүлэн бүрэн эрхийнхээ хүрээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрхийн акт гаргаж болно. Энэ эрхийн акт нь тогтоол хэлбэрээр байна.

Засгийн газар нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон тогтоол гаргахдаа тусгайлан эрх олгосон хуулийг иш үндэс болгоно."

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1997 оны 2 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар
хот

**Тогтоол хүчингүй болсонд
тооцох тухай**

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хууль баталсантай холбогдуулан уг хуулийг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн Монгол Улсын Их Хурлын 1993 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн "Дүрэм батлах тухай" 73 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1997 оны 2 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн
сонгууль товлон зарлах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 9 дүгээр зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийн санал хураалтыг 1997 оны 5 дугаар сарын 18-ны өдөр явуулахаар тогтоосугай.

2. Энэ тогтоолыг 1997 оны 3 дугаар сарын 4-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1997 оны 2 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн
зардлын хэмжээ тогтоох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд улсын төвлөрсөн төсвөөс зарцуулах зардлын хэмжээг 150 сая төгрөгөөр тогтоосугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

1997 оны 3 дугаар
сарын 28-ны өдөр

Улаанбаатар
хот

Улсын Их Хурлын 1997 оны хаврын чуулганыг
нээх, чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал
тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их
Хурлын 1997 оны 2 дугаар сарын 6-ны 16 тоот тогтоолыг үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:

Монгол Улсын Их Хурлын 1997 оны хаврын чуулганыг 4 дүгээр
сарын 5-ны өдөр нээж, дор дурдсан дарааллаар хуулийн төслүүдийг
хэлэлцүүдэхээр тогтоосугай:

1. Нотариатын тухай
2. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
3. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай
4. Аудитын магадлан шинэчлэлийн тухай
5. Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт
орлуулах тухай
6. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх
ажиллагааны тухай
7. Газрын дор болон хөдөлмөрийн хүнд, хортой, халуун нөхцөлд
ажиллагсдын салбарын даатгалын тухай
8. Амьжиргааны баталгаажих доод түвшингийн тухай
9. Хөдөлмөрийн хэлсний доод хэмжээний тухай
10. Хуулийн төсөл боловсруулах, өргөн мэдүүдэх журмын тухай
11. Эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр
12. Орон сууцны тухай ерөнхий хууль
13. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тухай
14. Архивын тухай
15. Улсын Их Хурлын сонгуулийн тухай
16. Иргэний хувийн өмчийн газрын тухай
17. Газар хувьчлах тухай
18. Хоршооны тухай
19. Шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай
20. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

21. Яамдын эрх зүйн байдлын тухай
22. Агентлагийн тухай
23. Гэр бүлийн тухай
24. Улс төрийн талаар хэлмэгдэгсдийг цагаатгах тухай
25. Хэвлэл, мэдээлийн хэрэгслийн тухай
26. Дайн бүхий байдлын тухай
27. Гадаадын цэргийн хүчийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай
28. Бусад

Дарга

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1997 оны 2 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 28

Улаанбаатар
хот

**Д. Батбаярыг Хөдөлмөрийн гавьяаны
улаан тугийн одонгоор шагнуулах
тухай**

Мэргэжлийн сумо бөхийн барилдааны ур чадварыг богино хугацаанд чадамгай эзэмшин Япон улсад зохиогддог үндэсний уламжлалт тэмцээнд тогтмол амжилттай оролцож улс орныхоо нэр хүндийг дэлхий дахинд түгээж спортын өндөр амжилт гаргаж байгааг нь үнэлж сумо бөхийн тамирчин Даваагийн Батбаярыг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнасуугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П.ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1997 оны 2 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 29

Улаанбаатар
хот

**Зарлигууд хүчингүй болсонд
тооцох тухай**

Цагдаагийн байгууллагын тухай болон Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан "Цагдаагийн тангараг батлах тухай" БНМАУ-ын Ерөнхийлөгчийн 1990 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 54, "Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын офицер, ахлагчдын тангараг батлах тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1992 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 1 дүгээр зарлигийг тус тус хүчингүй болсонд тооцсуугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1997 оны 2 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 31

Улаанбаатар
хот

Ц. Цэрэндоржид Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол олгох тухай

Тов, хөдөөгийн соёл урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж ерөөл, магтаал зэрэг ардын язгуур урлагийн төрлүүдээр бие даасан олон бүтээл туурвин тоглож дотоод, гадаадад, сурталчлах, залгамж үедээ өвлүүлэх болон сүүлийн жилүүдэд эзэн Чингисийн үеэс уламжлалтай төрийн хан хуур залах ёслолыг сэргээх, Монголын ерөөлч, магтаалч нарын төвийг байгуулах, ерөөлч, магтаалчдын улсын уралдааныг зохион байгуулах зэргээр ардын уламжлалт урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж Монголын ерөөлч, магтаалч, нарын төвийн тэргүүн Цэенгийн Цэрэндоржид Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1997 оны 2 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 32

Улаанбаатар
хот

Төрийн хянан шалгах байгууллагын зарим ажилтныг одон, медалнар шагнах тухай

Төр захиргаа, улс, олон нийтийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, сүүлийн жилүүдэд төрийн хянан шалгах байгууллагыг шинээр зохион байгуулж материаллаг бааз, боловсон хүчинээр бэхжүүлэх, төсвийн орлогын бүрэлдэлт, төсвийн зарцуулалт, төрийн өмчийн ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдлыг шалгаж, дутагдлыг арилгах, зөрчил төлбөрийг барагдуулж

улсыг хохиролгүй болгоход оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

“АЛТАН ГАДАС” ОДОНГООР

- | | |
|--------------------------|------------------------------------|
| 1. Лхамсүрэнгийн Жавзмаа | -Төрийн хянан шалгах хорооны дарга |
| 2. Дугарын Лхам | -Мөн хорооны ахлах хянан байцаагч |

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР

- | | |
|---------------------------|---|
| 1. Чойболын Сэндмаа | -Нийслэлийн хянан шалгах хорооны хянан байцаагч |
| 2. Өлгийтийн Нарангэрэл | -Өмнөговь аймгийн хянан шалгах хорооны хянан байцаагч |
| 3. Рагчаагийн Лхагвасүрэн | -Баянхонгор аймгийн хянан шалгах хорооны дарга |
| 4. Намнангийн Хүрлээ | -Төрийн хянан шалгах хорооны ахлах байцаагч |

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1997 оны 2 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 33

Улаанбаатар
хот

Зарим хүнийг “Алтан гадас”
одонгоор шагнах тухай

Төрийн байгууллага, үйлдвэртэл, үйлчилгээний салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийн хөдөлмөрийн амжилт, бүтээлийг үнэлж “Алтан гадас” одонгоор шагнасугай.

- | | |
|---------------------|-----------------------------|
| 1. Балдангийн Шатар | -Нутгийн өөрөө удирдах ёсны |
|---------------------|-----------------------------|

Архангай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгон, үйл ажиллагааг нь төлөвшүүлэх, орон нутагт төрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

2. Зундуйн Баттулга
Архангай аймгийн Эрдэнэбулган сумын иргэн, "Ургац" ХЭАА-н эзэн

-Хөдөө аж ахуйн үйлдвэртэлд олон жил үр бүтээлтэй ажиллаж, сүүлийн 5 жилд хувиараа аж ахуй эрхлэн гагаас авах ургацыг нэмэгдүүлж, 211.2 тн төмс, хүнсний ногоо хураан авч хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, хэрэгцээт үрээр хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

3. Шарав-Ариунийн Базар
Улсын төв номын сангийн хэлтсийн эрхлэгч

-Тус номын санд 30 гаруй жил үр бүтээлтэй ажиллаж зохион байгуулалтыг боловсронгуй болгох, материаллаг бааз, боловсон хүчинээр бэхжүүлэх, мэргэжлийн номын санчдыг бэлтгэх, номын хадгалалт хамгаалалтыг сайжруулахад оруулж байгаа хувь нэмэр болон номын сангийн судлал, ном зүйн талаар олон бүтээл туурвисныг нь үнэлж

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1997 оны 2 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 34

Улаанбаатар
хот

**Зарим шүүхийн шүүгчийг албан
тушаалаас нь чөлөөлөх тухай**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Базаррагчаагийн Оюунбилэгийг Говь-Алтай аймгийн шүүхийн шүүгчийн, Бадамгаравын Цэрэнбатыг Завхан аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Камланы Зулжашийг Баян-Өлгий аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Бадамгаравын Тогмидыг Говьсүмбэр аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Бавуугийн Түмэндэмбэрэлийг Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Лувсанхайдавын Баатар-Эрдэнийг Төв аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Балдандоржийн Нещагийг төв аймгийн хэсгийн ардын шүүхийн шүүгчийн Намдагийн Нямсүрэнг Хөвсгөл аймгийн хэсгийн ардын шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1997 оны 2 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 35

Улаанбаатар
хот

Шүүгчийг томилж тухай

Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Огшоо овогтой Эрдэнэтөгтохыг Баян-Өлгий аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр томилсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1997 оны 2 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 36

Улаанбаатар
хот

**В. Н. Меркуловыг "Алтан гадас"
одонгоор шагнах тухай**

Манай орны эрчим хүчний салбарын олон чухал объектуудыг барьж байгуулах, өндөр мэргэжлийн ажилчин, инженер техникийн ажилтныг сургаж бэлтгэхэд оруулсан дорвитой хувь нэмрийг нь үнэлж "Монгол энергострой" компанийн ерөнхий захирал, ОХУ-ын иргэн Валерий Николаевич Меркуловыг Алтан гадас одонгоор шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1997 оны 2 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 37

Улаанбаатар
хот

**Т. Мянмаржавыг Алтан гадас
одонгоор шагнах тухай**

Буудлагын спортоор олон жил хичээллэн тамирчин, дасгуулагчаар үр бүтээлтэй ажиллаж манай оронд энэ спортыг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Буудлагын спортын төв клубын орлогч дарга Түдэвийн Мянмаржавыг Алтан гадас одонгоор шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
ЗАРЛИГ**

1997 оны 3 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 39

Улаанбаатар
хот

**Шаравын Гунгаадоржийг элчин
сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх
тухай**

Өөр ажилд томилогдсонтой нь холбогдуулан Шаравын Гунгаадоржийг Монгол Улсаас Бүгд Найрамдах Казахстан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1997 оны 3 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 40

Улаанбаатар
хот

**Юмбуугийн Сандагийг элчин
сайдаар томилох тухай**

Монгол Улсаас Бүгд Найрамдах Казахстан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Юмбуугийн Сандагийг тохоон томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1997 оны 3 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 41

Улаанбаатар
хот

**Ишцогийн Очирбалыг элчин
сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх
тухай**

Өөр ажилд томилогдсонтой нь холбогдуулан Ишцогийн Очирбалыг Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1997 оны 3 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар
хот

**Кадырын Сайрааныг элчин
сайдаар томилох тухай**

Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Кадырын Сайрааныг тохоон томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ

1997 оны 3 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 43

Улаанбаатар
хот

Зөвшөөрөл олгох тухай

Шүүхийн ерөнхий зөвлөлийн хүсэлт, Шүүхийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 4.5 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгч Цэрэнхүү овогтой Батчимэгийг эрүүгийн хариуцлагад татах зөвшөөрөл олгож, түүнийг эрүүгийн хариуцлагад татсан өдрөөс эхлэн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас зохих шийдвэр гарах хүртэл шүүгчийн бүрэн эрхийг нь түдгэлзүүлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1997 оны 2 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 60

Улаанбаатар
хот

**Албан тушаалын цалин тогтоох,
эрэгтэлд хамааруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын 1997 оны 1 дүгээр тогтоолыг хэ-
згжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн даргын албан тушаалын сарын цалинг сум,
дүүргийн Засаг даргын албан тушаалын сарын цалинтай адил
байхаар тогтоосугай.

2. Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн даргын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн
хэмжээг албан тушаалын сарын цалингийн 10 хувиар тогтоож, 1997
оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн олгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

М. ЭНХСАЙХАН

Сэнгийн сайд

П. ЦАГААН

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1997 оны 3 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 61

Улаанбаатар
хот

Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр
зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас
ТОГТООХ нь:

Гонконг улсад 1996 оны 6 дугаар сарын 19-ний өдөр гарын үсэг
зурсан "Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслалц
тухай Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн
Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг баталсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

М. ЭНХСАЙХАН

Сэнгийн сайд

П. ЦАГААН

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1997 оны 3 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 62

Улаанбаатар
хот

Тогтоол хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

“ХБНГУ-ын Засгийн газраас олгосон зээлийн хөрөнгийг ашиглах тухай” Засгийн газрын 1996 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 319 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

М. ЭНХСАЙХАН

Сангийн сайд

П. ЦАГААН

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН
ХУУЛИЙН ЦЭШИЙН
ДҮГНЭЛТ**

1996 оны 9 дүгээр
сарын 4-ний өдөр

Дугаар 7

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд
нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуультай
холбогдсон маргааныг хянан хэлэлцсэн
тухай**

Үндсэн хуулийн цэцийн энэ дүгнэлтийг 1996 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр төрийн ордны 251 дүгээр тасалгаанд үйлдэв. Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг цэцийн дарга Г. Сова даргалж гишүүдэд Л. Балсан, Ж. Бямбаа, С. Жанцан, Д. Чидхаажав /илтгэгч/ нар оролцов. Цэцийн хуралдааны нарийн бичгийн дарга Б. Цэндээхүү, маргагч талыг төлөөлж Сүхбаатар дүүргийн иргэн Г. Ганболд, Монгол Улсын дээд шүүхийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ч. Дашням, Улсын Их хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга С. Батчулуун, Улсын Их Хурлын гишүүн С. Баярцогт, Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Хууль зүйн яамны төрийн нарийн бичгийн дарга Д. Сугар нар тус тус оролцов.

Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн иргэн Г. Ганболд Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөл, түүнд холбогдуулан өгсөн тайлбартаа доорхи асуудлыг тавьж байна. Үүнд:

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Шүүхийн байгууллагын зохион байгуулалт, санхүү, материал-техникийн хангамж үйлчилгээ"-г хууль зүйн сайд эрхлэхээр тусгасан заалт нь Монгол Улсын үндсэн хуулийн "Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана. Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажилд оролцохгүйгээр гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийн бие даан ажиллах нөхцөлийг хангахтай холбогдсон үүргийг биелүүлдэг. Шүүхийн ерөнхий зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно" гэсэн 19 дүгээр зүйлийг бүдүүлдгээр зөрчиж буй нь дараах байдлаар илэрч байна. Үүнд:

Үндсэн хуулиар шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг шүүх өөрөө л хангахаас гүйцэтгэх засаглал, тэр

тусмаа ямагт төсөв хөрөнгөө барьж байдаг Засгийн газрын байгууллага хангахгүй. Нөгөө талаар төсөв хөрөнгөөр барьцаалж Засгийн газар шүүх хуулийн гадна үлдэх боломжийг бий болгож байна. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлын баталгаа болсон Ерөнхий зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтоох үндсэн хуулийн заалтыг зөрчиж хуулиас дээгүүр дүрэм /ямны/ гаргаж түүний зохион байгуулалт үйл ажиллагааг зохицуулж эхлэхэд хүрч байна.

Нэг эрх мэдлийн бие даасан байдлыг нөгөө эрх мэдэл хангана гэж үгүй. Нөгөө талаар хэрэв үнэхээр л шүүхийн ерөнхий зөвлөлийг Засгийн газрын бүтцэд байгуулж шүүхийн зохион байгуулалт, санхүү, боловсон хүчний асуудлыг хариуцуулах байсансан бол Үндсэн хууль юу гэж шүүх эрх мэдлийн тухай бүлэгтээ энэ асуудлуудыг авч үзэх билээ. Ийм болохоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Хууль зүйн сайд байх тухай заалт ч утга үндсэн хууль зөрчиж байгаа юм.

Шүүхийн зохион байгуулалтын асуудлыг Хууль зүйн сайд эрхэлснээр хуулиар байгуулагдах учиртай шүүхийг Засгийн газар байгуулж, дуртай үедээ, дуртай газраа, дуртай хүмүүсээс бүрдсэн, дуртай асуудлаа шийддэг шүүх байгуулахад хүргэхгүй гэх үндэсгүй юм.

Иймд үндсэн хуулийн баталгаа болсон Монгол улсын Үндсэн хуулийн цэц олон талаас нь нягтлан үзэж нухацтай шударга шийдвэр гаргана гэдэгт найдаж байна гэжээ.

Монгол улсын дээд шүүхийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ч. Дашням Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа: Шүүхийн байгууллагын зохион байгуулалт гэдэгт шүүхийг байгуулах, өөрчлөх, татан буулгах, байршил, орон тоог тогтоох, шүүгчийг шилж олох, шалгаруулах, бэлтгэх, давтан сургах зэрэг ажил ордог билээ. Гэтэл тэдгээрийг Хууль зүйн сайдын эрхлэх ажилд хамруулснаар Үндсэн хуулийн цэцэд заасан шүүх эрх мэдлийн байгууллагын бүрэн эрхийн асуудлыг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад шилжүүлж, Үндсэн хуулийн байгууллага болох Шүүхийн ерөнхий зөвлөлийг Засгийн газрын нэг сайдын ажлын албаны хавсарга болгоход хүргэсэн байна.

Түүнчлэн Засгийн газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийг үндэслэн Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Ерөнхий зөвлөлийн ажлын албаны бүтэц зохион байгуулалтыг Засгийн газар тогтоохоор заасан нь Ерөнхий зөвлөл гүйцэтгэх засаглалын хараат байдалд орж шүүхийн хараат бус байдлыг хангах Үндсэн хуулийн байгууллага бус, Хууль зүйн сайдын эрх үүргийг хэрэгжүүлэгч нэг механизм, ор нэрийн төдий, Хууль зүйн яамны аппаратын хавсарга байгууллага болж буй нь бүр ч

тодорхой харагдаж байна.

Энэ бүхэн нь шүүх, шүүгчийн бие дааж хараат бусаар ажиллах тухай үндсэн хуулийн заалт зарчмыг ноцтой зөрчсөн гэж үзэж болох бүрэн үндэстэйг баталж байх тул Засгийн газрын хуульд өөрчлөлт оруулах тухай 1996 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн хуулийг Үндсэн хууль зөрчсөн болохыг тогтоосон дүгнэлт гаргаж өгөхийг хүсч байна гэжээ.

Монгол Улсын Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Хууль зүйн яамны төрийн нарийн бичгийн дарга Д. Сугар Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа: Засгийн газрын хууль, Засгийн газрын 1994 оны 46 дугаар тогтоолын дагуу Хууль зүйн сайд хуульч боловсон хүчнийг сургах, давтан бэлтгэх асуудлыг хариуцаж байгаа бөгөөд шүүгчийн эрх ашгийг хамгаалахад хөндлөнгөөс илүү бодитой хандаж оролцох үндэслэлтэй. Үүнээс гадна Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн олонхийг хуучны адил шүүгчид бүрдүүлэх юм. Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах механизмыг хуулиар бий болгосон ба түүнийг зөвхөн шүүхдээ байна гэдгийг тогтоосон хууль байхгүй. Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүнд Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгчийн төлөөлөгчдийг оролцуулан, Зөвлөлийн дарга дээрх газрын төлөөлөгчдөөс хэн нь ч байх боломжийг хуулинд тусгасан нь үүнийг нотолж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга нь Хууль зүйн сайд болсноор энэ байгууллага Засгийн газрын байгууллага боллоо гэж дүгнэх хууль зүйн үндэслэл байхгүй байна. Учир нь бүрэлдэхүүн болон зөвлөлийн бүрэн эрх нь иргэн Г. Ганболдын гомдол гаргахаас өмнөх байдлаас өөрчлөгдөөгүй байна. Шүүхийн төсвийг Засгийн газар биш Улсын Их Хурал баталдаг бөгөөд төсвийн төслийг Шүүхийн Ерөнхий зөвлөл урдах бүрэлдэхүүнээрээ боловсруулж холбогдох газар оруулах учир төсвийг Засгийн газар мэдэж, түүгээрээ барьцаалан шүүхийн гадна үлдэнэ гэсэн дүгнэлт нь хууль зүйн үндэслэлгүй, гүтгэлгийн шинжтэй дүгнэлт болжээ.

Шүүхийн санхүү, материал-техникийн хангамж, үйлчилгээний стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр зохицуулалт, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх гэдэг нь шүүх, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газрын "дундын" шинжтэй байгууллага болох Шүүхийн ерөнхий зөвлөлөөс боловсруулсан бодлого чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг Засгийн газрын гүйцэтгэх байгууллага хариуцахаас шүүх өөрөө хариуцах тухай ойлголт байж болохгүйтэй холбоотой.

Иймд эдгээр заалтыг шүүхийн хараат бус, бие даасан байдлыг зөрчсөн гэх үндэслэл байхгүй болно гэжээ.

Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн С. Баярцогт, Хууль зүйн байнгын хорооны дарга С. Батчулуун нар Үндсэн хуулийн цэцэг ирүүлсэн тайлбартаа: Засгийн газрын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль нь Монгол Улсын шүүх эрх мэдлийн талаархи Үндсэн хуулийн 4 дүгээр бүлгийн 47, 48, 49, 50 дугаар зүйлийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй болно. Монгол Улсын хууль тогтоомжоор шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн эрхлэх асуудал, үйл ажиллагааны хүрээ заагийг ялгаатай болгохыг баталгаажуулсан болно. Ийм учраас шүүх болон гүйцэтгэх эрх мэдэл нэг нь нөгөөгөөсөө хараат болсон тухай ойлголт нь хууль зүйн үндэслэлгүй гэж үзэж байна.

Шүүхийн төсөв, үйл ажиллагааг явуулах эдийн засгийн баталгааг төрөөс хангаж, шүүхийн төсвийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Улсын Их Хурал баталж, улсын төвлөрсөн төсөвт тусгах тухай Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 60 дугаар зүйлд тус тус заасан бөгөөд Засгийн газрын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэхэмжлэлд дурьдсан заалт дээрх заалтуудтай зөрчилдөөгүй болно гэжээ.

Иргэн Г. Ганболд Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд оролцож тайлбарлахдаа: Улс төрийн нэг нам засгийн эрхэнд гармагцаа шүүхийн байгууллагын зохион байгуулалт, санхүү, материал техникийн хангамж үйлчилгээг хариуцах эзнийг өөрчлөөд байвал төрийн ялын бодлогод ч ноштой нөлөөлж болох юм гэв. Улсын дээд шүүхийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ч. Дашням Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбартаа: Шүүх өөрөө хараат бус байдлаа бужуу санхүү, материал-техникийн хангамж үйлчилгээгээ өөрөө хариуцан шийдэж байгаа биш Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн тамгын газар л хариуцаж байгаа юм. Энэ асуудлыг Хууль зүйн сайд эрхлэхээр болсон нь шүүхийн ерөнхий зөвлөлийн хийх ажлыг Хууль зүйн сайд эрхлэхээр боллоо гэж би хувьд ойлгож байна. Энэ хуулиар шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх үүргийг Хууль зүйн сайдад давхардуулан шилжүүлснээр Үндсэн хууль зөрчөөд байгаа юм гэв.

Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн С. Баярцогт Үндсэн хуулийн цэцийн хуралдаан дээр гаргасан тайлбартаа: Улсын Их Хурлын 1996 оны 7 дугаар сарын 26, 29-ний хуулинд орсон өөрчлөлтөөр шүүхийн Ерөнхий зөвлөлийн үүргийг давхардуулаагүй. Ерөнхий зөвлөлийн үүрэг хуулийн дагуу яваандаа хэрэгжих л болно.

Засгийн газрын болон Шүүхийн тухай хуулинд орсон нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн заалтыг зөрчөөгүй гэв. Монгол Улсын

газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч Хууль зүйн яамны төрийн нарийн бичгийн дарга Д. Сугар Үндсэн хуулийн цэцийн хуралдаан дээр гаргасан тайлбартаа: Дээд шүүх, орон нутгийн шүүхүүд өөрийн Тамгын газартай байх бөгөөд энэ нь зөвхөн шүүхдээ л байна. Аймгийн засаг даргын Тамгын газарт хуулийн хэлтэс гэж байгуулагдаагүй. Энэ нэмэлт, өөрчлөлтөөр харин шүүх аж ахуй хангамж муу байвал сайжруулах талаар Засгийн газарт хүсэлт шаардлага тавих эрх зүйн үндэстэй болж байгаагаараа хараат бус бие даасан байдал нь баталгаажиж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын аппарат нь Хууль зүйн сайд-ын дэргэд байхаар Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан. Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэн эрх, хууль зүйн сайдын бүрэн эрх хоёр ялгаатай. Шүүх шүүн таслах үйл ажиллагаагаа явуулахдаа л хараат бус бие даасан байх болохоос аж ахуй хангалтын асуудлаа өөрсдөө хийснээр хараат бус бие даасан байдал нь баталгаажина гэж үзэж болохгүй гэжээ.

ХЯНАВАЛ:

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 3 дугаарт "... шүүхийн байгууллагын зохион байгуулалт, санхүү, материал-техникийн хангамж, үйлчилгээ . . ." -ний хүрээний стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөгөлбөр, зохиох, зохицуулалт, хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлж дүгнэх ажлыг Хууль зүйн сайд эрхлэхээр оруулсан нь Үндсэн хуульд заасан Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх үүргийг Засгийн газарт шилжүүлсэн бус Шүүхээс зөвхөн шүүн таслах эрх мэдлээ хэнээс ч хараат бус бие даасан байдлаар хэрэгжүүлэх нөхцөл бололцоог хангахад чиглэгдсэн байна.

Иймээс энэ талаархи иргэн Г. Ганболдын гомдлыг хангах боломжгүй байна.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН 66 ДУГААР ЗҮЙЛ, МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 19 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙГ УДИРДАГА БОЛГОН ГАРГАХ ДҮГНЭЛТ

1. "Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 1996 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн хуулийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 3 дугаарт Монгол Улсын хууль зүйн сайдад . . . шүүхийн байгууллагын зохион байгуулалт, санхүү, материал-техникийн хангамж үйлчилгээ . . . -г Монгол

Улсын Засгийн газрын гишүүний хувьд стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр зохиох, зохицуулалт, хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх үнэлж дүгнэх ажлыг хариуцсаны хувьд эрхлүүлсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 3,4,5-р заалтыг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг Улсын Их Хурлын намрын чуулган эхэлснээс хойш 15 хоногийн дотор мэдэгдэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилж байна.

Дарга
Гишүүд:

Г. СОВД
Л. БААСАН
Ж. БЯМБАА
С. ЖАНЦАН
Д. ЧИЛХААЖАВ

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН
ХУУЛИЙН ЦЭЦИЙН
ДҮГНЭЛТ**

1996 оны 10 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 8

Улаанбаатар
хот

**Өршөөл үзүүлдэх тухай Монгол Улсын
хуультай холбогдсон маргааныг
хянан хэлэлцсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн энэ дүгнэлтийг 1996 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Төрийн ордон-1 251 дүгээр тасалгаанд үйлдэн. Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг цэцийн дарга Г. Совд даргалж, гишүүдэд Л. Баасан, Н. Жанцан /илтгэгч/, Д. Чилхаажав, Ж. Бямбажав нар оролцов. Цэцийн хуралдааны нарийн бичгийн даргаар цэцийн нарийн бичгийн дарга Б. Цэндээхүү, маргагч талыг төлөөлж Чингэлтэй дүүргийн иргэн Д. Хувьтөгөлдөр, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн С. Батчулуун, С. Төмөр нар оролцов.

Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн иргэн Д. Хувьтөгөлдөр Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөл, түүнд холбогдуулан өгсөн тайлбартаа доорх асуудлыг тавьж байна. Үүнд: Монгол Улсын тулгар төр байгуулагдсаны 790 жилийн ойг тохиолдуулан "Эмэгтэйчүүд, хүүхэд, 60-аас дээш насны хүмүүст" Монгол Улсын Ерөнхийлөгчийн санлаачилгаар өршөөл үзүүлдэх тухай хуулийн төсөл боловсруулж, уг төслийг Монгол Улсын Их Хурлын ээлжит бус чуулганаар хэлэлцүүлж баталсан юм. Үүнтэй холбогдуулж уучлал

үзүүлэх, өршөөл үзүүлэх гэсэн ойлголтын цар хүрээг бодох нь зүйтэй. Хэрвээ бүх ялтныг хамааруулахгүй, цөөн тооны хүмүүсийг өршөөх асуудал тавьж байгаа бол Улсын Их хурал Өршөөл үзүүлэх тухай хууль биш, Ерөнхийлөгч уучлал үзүүлэх тухай зарлиг гаргах ёстой. Өршөөл үзүүлдэг байгаа бол хорих байгууллагад хоригдож буй бүх ялтныг хамруулах нь зүйтэй. Өршөөл үзүүлэхдээ ингэж "60-аас дээш насны эрэгтэйчүүд" гэсэн хязгаар тогтоож байгаа явдал нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд заагдсан "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна", мөн "хүнийг . . . нас, хүйсээр ялгаварлан гадуурхаж үл болно" гэсэн заалт, 16 дугаар зүйлийн 11-д заагдсан "Улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй", "гэр бүл, эх няхас хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална" гэсэн заалтуудыг Монгол Улсын Их Хурлын 1996 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн тогтоол зөрчиж байна гэж үздэг.

Иймд Өршөөлийн тухай хуулинд 18-60 насны эрэгтэй хоригдлуудыг бусалд хоригдлуудтай адилтгаж хүний эдлэх ёстой эрхийг нь Үндсэн хуульд зааснаар эдлүүлэх шаардлагатай гэж үзээд Улсын Их Хурлын тогтоолын заалт Үндсэн хуулийг зөрчсөн хэмээн үзэж байгаа тул энэ асуудлыг хэрэг үүсгэн хянан шийдвэрлэж өгнө үү гэжээ.

Улсын Их хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн С. Батчулуун, С. Төмөр нар Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:

1. Эрүүгийн хуулиар гэм буруутай этгээдийн хувийн байдал, хэргийг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзэх нь ял оногдуулах нийтлэг зарчим юм.

Гэм буруутай этгээдийн хувийн байдал гэдэгт түүний нас хүйс, гэр бүлийн байдал зэрэг асуудал хамаардаг болно. Тийм ч учраас Эрүүгийн хуулийн дагуу ял ногдуулахдаа дээрх үндэслэлийг харгалзан үздэг. Тухайлбал:

1/ Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлд 18 нас хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, эмэгтэйчүүд, 60-аас дээш насны эрэгтэйчүүдэд шаазар авах ял ногдуулахгүй байх;

2/ Эрүүгийн хуулийн 22 дугаар зүйлд дээрх хүмүүст 15-аас дээш жил хорих ял ногдуулахгүй байх;

- Эрүүгийн хуулийн 42 дугаар зүйлд насанд хүрээгүй хүмүүсийн гаслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахаар тогтоосон байдаг.

2. Ялыг хөнгөрүүлэх нөхцөл байдалд насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдсэн, 7 хүртэл насны хүүхэдтэй буюу жирэмсэн

эмэгтэй гэмт хэрэг үйлдсэнийг хамруулан үзэхээр Эрүүгийн хуулийн 15 дугаар зүйлд заасан.

3. Ялаас хутагцааны өмнө чөлөөлөх, хөнгөн ялаар солих үндэслэл нь:

- Гэмт хэргийн хүнд, хөнгөн байдал.
- Ялтны засрал хүмүүжил.
- Ялын хугацаа, төрөл зэрэг асуудлыг хамардаг.

Мөн насанд хүрээгүй этгээдийн хувьд тусад нь ялгамжтай зохицуулж өгсөн.

Иймд ялаас чөлөөлөх нэг хэлбэр болох өршөөл үзүүлэх тухай хууль нь ял оногдуулах болон ялаас чөлөөлөх үндсэн зарчмын дагуу гарсан тул энэ үндэслэлээр хууль, шүүхийн өмнө иргэд тэгш байх Үндсэн хуулийн зарчмыг зөрчөөгүй гэж үзэж байна гэжээ.

Гомдол гаргагч иргэн Д. Хувьтөгөлдөр Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд оролцож тайлбар гаргахдаа: Өршөөл үзүүлж байгаа явдал нь ял оногдуулж байгаагаас эрс ялгаатай бөгөөд энэ хоёрыг адилтгаж болохгүй. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн тайлбарт Эрүүгийн хуулийн заалтыг ишлэл болгон авсан нь энэхүү өршөөл үзүүлэхэд огт хамааралгүй зүйл юм. Хэрэв Ерөнхийлөгч өршөөлийн зарлиг гаргасан бол Үндсэн хууль зөрчсөн гэж би үзэхгүй. Улсын Их Хурал хууль гаргасан нь Үндсэн хууль зөрчиж байгаа юм.

Хүн бүр хуулийн өмнө тэгш эрхтэй байгаа тул ялтан ч адилхан хүн гэдгийг ойлгох ёстой. Би энэ хуулийг дутуу зохицуулалттай хууль гэж үзэхгүй Үндсэн хууль зөрчсөн хууль гэж үзэж байгаа тул Үндсэн хуулийн цэцэд хандсан юм гэлээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч С. Төмөр Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд оролцож хийсэн тайлбартаа: Өршөөл үзүүлэхдээ бүх хоригдлыг хамааруулах тухай хуулийн ямар ч заалт манайд байхгүй. Иймд тодорхой хязгаар тогтоох эрхтэй. Энэ нь тогтсон практик юм. Энэ нь манай төрийн хүчлэг энэрэнгүй бодлогын нэг илрэл юм. Манай Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн хүнд ялгамжтай ял оногдуулахаар тодорхой үндэслэлүүд заасан байдаг. Эрүүгийн хуульд насанд хүрээгүй хүмүүс, эмэгтэйчүүд, 60-аас дээш насны хүмүүст хөнгөлөлт үзүүлэх нөхцөлийг заасан нь хуулийн бас нэг үндэслэл юм.

Өршөөлийн хувьд Улсын Их Хурал тогтоол гаргаж болохгүй. Энэ бол хүний эрхтэй холбоотой учир зөвхөн хууль гаргах ёстой гэжээ. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч С. Батчулуун хэлэхдээ: Өршөөлийн хууль бол онцлог хууль. Ерөөсөө эрх нь хязгаарлагдсан хүмүүст хандаж байгаа учраас тодорхой хязгаарлалтыг заавал

шаардаг. Энэ хуулийг батлахдаа хууль саналчлагчийн өргөн барьсан төслийн үндсийг Улсын Их Хурал хадгалах бодлого баримталсан юм. Ятган гэдэг бол эрх нь хязгаарлагдсан хүмүүс гэдгийг санах ёстой. Энэ агуулгаараа Өршөөлийн хууль Үндсэн хууль зөрчөөгүй юм гэжээ.

Хянавал:

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 14-т зааснаар Өршөөл үзүүлэх шийдвэр гаргах эрх нь Монгол Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаарагдаж байна. Улсын Их Хурал энэхүү бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ тухайн цаг үеийн нөхцөл байдлаас болж ямар үзүүлэлтийг гол шалгуураа болгох нь мөн түүний бүрэн эрхэд хамаарах юм гэж үзэх үндэслэлтэй байна.

Монголын тулгар төр үүсгэн байгуулсны 790 жилийн ойт тохиолдуулан Монгол Улсын Их Хурал Өршөөл үзүүлэх тухай хууль гаргахдаа эмэгтэйчүүд, хүүхэд, 60-аас дээш насны эрэгтэйчүүд гэсэн үзүүлэлтүүдийг ялаас чөлөөлөх буюу хөнгөрүүлэх гол шалгуур болгосон нь хууль тогтоох дээд байгууллагын эрх хэмжээний асуудал бөгөөд өршөөлд хамаарагдаагүй ктны эрхийг хязгаарласан заалт байхгүй тул үүнийг Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Иймд энэ талаар гаргасан иргэн Д. Хувьсөгөдөрийн гомдлыг хангах үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн удирдлага болгон дүгнэлт гаргах нь:

1. Монголын тулгар төрийг үүсгэн байгуулсны 790 жилийн ойт тохиолдуулан насанд хүрээгүй эгтээд, эмэгтэйчүүд, 60, түүнээс дээш насны эрэгтэйчүүдэд өршөөл үзүүлэх тухай Монгол Улсын хууль Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй байна.

2. Цэцийн энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хянан хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

Дарга

Г. СОВД

Гшшүүд:

Л. БААСАН
Н. ЖАНЦАН
Д. ЧИЛХААЖАВ
Ж. БЯМБАЖАВ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН
ХУУЛИЙН ЦЭЦИЙН
ДҮГНЭЛТ

1996 оны 12 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 9

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засаг захиргаа,
нутаг дэвсгэрийн нэгж, түүний
удирдлагын тухай хуулийн 10
дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт
Монгол Улсын Үндсэн хуулийг
зөрчсөн эсэх талаарх маргааныг
хянан шийдвэрлэсэн тухай

Төрийн ордны 251 дүгээр өрөө

Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Н. Жанцан даргалж, гишүүдэд Л. Баасан /илтгэгч/ Ж. Бямбажав, С. Жанцан, Д. Чилхаажав нар, нарийн бичгийн даргаар Б. Цэндээхүүг оролцуулан хийв. Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд өргөдөл гаргагч иргэн С. Нарангэрэл, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч С. Батчулуун, Э. Бат-Үүл, С. Баярцогт нар оролцов.

Нэг. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хорооны иргэн Содовсүрэнгийн Нарангэрэл Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөл, түүнтэй холбогдуулан өгсөн тайлбартаа: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн дөрөв дэх хэсэгт заасан "дахин нэр дэвшүүлсэн хүнийг томилохоос татгалзсан нөхцөлд дээд шатны Засаг дарга доод шатны Засаг даргыг, Ерөнхий сайд аймаг, нийслэлийн Засаг даргыг тухайн шатны Хуралтай зөвшилцөн томилно" гэсэн хэм хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй, түүний дараах заалтыг зөрчсөн байна.

1. Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт буй "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна" гэснийг,

2. Мөн хуулийн 16 дугаар зүйлийн 9-т "хүн бүр шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй" гэж тогтоосныг,

3. Мөн хуулийн 1 дүгээр зүйлийн хоёр дахь хэсэгт "Ардчилсан ёс . . . нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэснийг,

4. Мөн хуулийн 60 дугаар зүйлийн хоёр дахь хэсэгт "Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны хуртаас

нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн засаг даргыг Ерөнхий сайд
томилно” гэж заасныг;

5. Мөн хуулийн 16 дугаар зүйлийн 10-г “Аль нэгэн нам, олон
нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон
гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг
хориглоно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Ийнхүү Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх
зарчмаас ухарч ард түмэн өөрсдийн сонгосон төлөөлөгчдийнхөө
байгууллагаар уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхийг
илгэд хязгаарлаж, төрийн үйл ажиллагааны ардчилсан ёсны зарчмыг
ноцтой хөсөрдүүлж, өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай
хослуулах зарчмыг гүйтвуулж, нутгийн өөрөө удирдах байгууллагаас
Засаг даргад нэр дэвшүүлсэн шийдвэрийг Ерөнхий сайд хүндэтгэн,
нэр дэвшигчийг томилж, түүнд төрийн төлөөлөгчийн эрх хэмжээ
олгоход саад учруулж, нэр дэвшигчийг нэг удаа татгалзаж болох
Үндсэн хуулийн үзэл баримтлалыг “зөвшилцөх” нэрийдлийн дор
Ерөнхий сайдад Хурлаас дэвшүүлсэн Засаг даргад нэр дэвшигчийг
нөхөн намын харьяалал, үзэл бодлоор нь гол шалгуур болгон
татгалзах, томилж эргээр дур зоргоороо авирлах боломжийг олгож,
эрон нутгийн сонгуульд Монголын ард түмний хийсэн сонголтын
ер дүнг үл ойшоон улацала гишгэх нөхцөлийг бүрдүүлдсээрээ
Монгол Улсын Үндсэн хуулийн олон заалт нэгэн зэрэг зөрчигдсөн
үл Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний
дирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн дөрөв дэх хэсгийг
үхэлд нь хүчингүй болгох зорилгоор энэхүү өргөдөл, тайлбарыг
аргав гэжээ.

Хоёр Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их
Хурлын гишүүн С. Батчулуун, Э. Бат-Үүл, С. Баярцогт нар бичгээр
трүүлсэн тайлбаргаа:

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хорооны иргэн С.
Зарангэрэлийн өргөдөлд дурдсан шаардлагууд нь үндэстэлгүй байна.
(үнийг дор дурдсан тайлбаруудаар тодорхойлж болно. Үүнэ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн нэг дэх
эсгийн “Монгол Улсад бүх эрх ард түмний мэдэлд байна” гэсэн
заалт зөрчигдөөгүй болох талаар.

Үндсэн хуулинд Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд
айгууллага мөн, Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд
айгууллага мөн, Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл
айна, Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид
уваагдана гэж заасан Ард түмэн сонгосон Улсын Их Хурал
олон түүнээс томилсон Засгийн газар, Засгийн газрын Ерөнхий
ийдын томилсон аймаг, нийслэлийн засаг дарга, мөн шат

сайдын томилсон аймаг, нийслэлийн засаг дарга, мөн шат дараалан томилсон сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нар төрийн удирдлагыг хэрэгжүүлдэг. Энэ нь Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна гэсэн заалтыг хэрэгжүүлж байна гэж ойлгодог.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9-д хүн бүр "шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийн удирдах хэрэгт оролцох эрхтэй" гэсэн заалт зөрчигдөөгүй талаар.

Бүх шатны Засаг даргын албан тушаал нь төрийн улс төрийн томилолтын албан тушаал юм. Иймд Үндсэн хуулийн энэ заалт нь тухайн асуудалтай шууд холбогдолгүй болно.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалт зөрчигдөөгүй болох талаар.

Улсын Их Хурлын сонгуульд ялсан нам, эвсэл нь өөрийн Засгийн газрыг байгуулж, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг Монгол Улсын засаг захиргааны аль ч нэгжид хэлбэрэлтгүй биелүүлдэхийг иш үндэс болгон ажиллаж байгаа нь Үндсэн хуулийн дээрх заалттай бүрэн нийцэж байгаа юм.

4. Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд . . . томилно" гэсэн заалт зөрчигдөөгүй болох талаар.

Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 3 дахь заалтанд "Ерөнхий сайд буюу дээд шатны нэгжийн Засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмаар дахин нэр дэвшүүлж томилтол өмнөх Засаг дарга бүрэн эрхээ хэвээр хадгална" гэж заасан. Энэ нь Ерөнхий сайд болон дээд шатны Засаг дарга нар нь томилохоос татгалзах эрхийг бүрэн зөвшөөрснөөр Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 2 дахь заалт зөрчигдөж байна гэдэг үндэслэлгүй юм.

Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 3-т заасан үйл явц хэдэн удаа үргэлжилж болох юм. Үүнээс яаж гарах вэ гэдэг асуудал Үндсэн хуульд зохицуулалтгүй орхигдажээ.

Энэхүү зохицуулалтгүй орхисон хэм хэмжээг "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-д нарийвчлан хуульчлахдаа Үндсэн хуульд тусгалаа олсон . . . зөвшлийн зарчмыг төсөөтэйгээр ашигласан нь Үндсэн хуульд нийцсэн түүний заалтыг зөв зүйтэйгээр баяжуулсан гэж үзэх бүрэн үндэстэй.

5. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10-т "аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвтэдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаврлан гадуурхах, төлөө

хэлмэгдүүлэхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчөөгүй болох талаар.

Монгол Улсад төрийн албаны ангилал, зарчим төрийн албан тушаал, түүнд тавих шаардлага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, түүнээс төрийн алба хаах болзол, журам, баталгаа тогтоох асуудлыг Төрийн албаны тухай хуулиар зохицуулдаг. Уг хуулиар тогтоосон төрийн албаны ангиллын нэг нь улс төрийн алба бөгөөд улс төрийн албан тушаалд Монгол улсын Ерөнхийлөгч, Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Их Хурлын дэд дарга, гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн . . . бүх шатны засаг дарга багтдаг. Энэ нь Монгол Улсын төрийн нийт албан хаагч 141,5 мянган хүний 1,6 хувь буюу нийт 2300 хүн байдаг бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их хурлын сонгуулийн дүнгээс шалтгаалан өөрчлөгдөх ёстой юм. Иймээс төрийн улс төрийн албан тушаал болох бүх шатны засаг даргын томилолтын асуудал нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10-т заасан заалттай шууд холбогдолгүй болно гэжээ.

Гурав Улсын Их Хурлын итгэмжтэгдсэн төлөөлөгчийн тайлбартай холбогдуулан гомдол гаргагч иргэн С. Нарангэрэл нэмэгдэл судалгаа хийх, нотлох баримт бүрдүүлэх тухай хүсэлт гаргасан учир Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаас 1996 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр 07 тоот магадлал гарган Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг хойшлуулжээ.

Дөрөв. Гомдол гаргагч иргэн С. Нарангэрэл Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд оролцож тайлбарлахдаг. Цэцийн гишүүн Л. Баасан миний өргөдөл, нэмэлт, тайлбарыг дэлгэрэнгүй тайлбарласан тул доорх зүйлийг нэмж тайлбарлая.

1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар Засаг даргыг сонгож нэр дэвшүүлэх үү, гэдгийг дээрээс нь томилох уу гэдэг үзэл баримтлалын үндэслэлийг Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэж байсан баримтаар тайлбарлая. Энэ хуулийг батлахад Э. Бат-Үүл, С. Баярсонот, С. Батчулуун нар оролцсон болохоор асуудлыг сайн мэдэж байгаа.

Үндсэн хууль хэлэлцсэн протоколоос үзэхэд аль ч шатны Засаг даргыг Хурлаас ямагт нэр дэвшүүлэх дараа нь томилох үзэл баримтлал бий. Гэтэл Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4-т “томилох” гэсэн утга тусгагдсан.

2. Хуулийн дээрх заалтаас шалтгаалан Монгол Улсын Ерөнхий сайд М. Энхсайхан Үндсэн хууль зөрчихөд хүрч байна. Үүнийг Насан-Очир, Мэнбилэг нарыг аймгийн засаг даргад ажиллуулахаас ятгалзсанаар тайлбарлаж болно.

Би асуудалд улс эх орны эрх ашгийн үүднээс хандсан тэдгийг цэцийн эрхэм гишүүд анхаараасай гэж хүсч байна.

Тав. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч С. Батчулуун цэцийн хуралдаанд оролцож тайлбарлахдаа хуульч С. Нарангэрэлийн тайлбарыг сонслоо. Асуудлыг хууль зүйн талаас нь тавихдаа улс төрийн хувьд зөрчилтэй болгожээ. Тодорхой тайлбар гаргахад:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар бүтэц бол Монголд гүйцэтгэх засаглалыг хүчтэй болгоход чиглэгджээ.

Энэ утгаараа Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4-т Ерөнхий сайд дээд шатны Засаг дарга нар нэр дэвшигчийг татгалзах, энэ үндсэн дээр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөн зарим Засаг дарга нарыг томилох тухай заасан. Энэ бол гүйцэтгэх засаглалыг хүчтэй болгосон механизм болно.

2. Ерөнхий сайд аймгуудын Засаг дарга нарыг томилохдоо намын байдлаар ялгаварласан гэх үндэслэл байхгүй. тухайлбал 19 аймгийн Засаг даргыг томилоход МАХН-ын олон гишүүд багтсан байна. Дээрхээс үндэслэн үзэхэд иргэн С. Нарангэрэлийн шаардлагыг хүлээн авах үндэслэлгүй байна гэжээ.

Хянават:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4-т буй "Дахин нэр дэвшүүлсэн хүнийг томилохоос татгалзсан нөхцөлд дээд шатны засаг дарга доод шатны засаг даргыг, Ерөнхий сайд аймаг, нийслэлийн Засаг даргыг тухайн шатны Хуралтай зөвшилцөн томилно" гэсэн заалт нь:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 3-т буй "Ерөнхий сайд буюу дээд шатны нэгжийн Засаг дарга, доод шатныхаа нэгжийн Засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмаар дахин нэр дэвшүүлж томилтол өмнөх Засаг дарга бүрэн эрхээ хэвээр хадгална" гэсэн хэм хэмжээг өргөтгөн бүх шатны Засаг даргыг гурав дахь удаагаа нэр дэвшүүлэх, эсхүл зөвшилцөх гэх мэтгйн зохицуулалтыг тус тус буй болгосон байна.

2. Засаг даргыг зөвшилцөн томилох тухай хэм хэмжээ Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдаагүй байна.

Энэ утгаар нь авч үзэхэд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн холбогдох заалтуудыг зөрчжээ гэж үзэх үндэслэлтэй байна.

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн иргэн С. Нарангэрэлийн

гомдлын энэ талаарх хэсгийг хүлээн авах үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон дүгнэлт гаргах нь:

1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4-т "Дахин нэр дэвшүүдсэн хүнийг томилохоос татгалзсан нөхцөлд дээд шатны засаг дарга доод шатны Засаг даргыг, Ерөнхий сайд аймаг, нийслэлийн засаг даргыг тухайн шатны Хуралтай зөвшилцөн томилно" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 2, 3 дахь заалтыг зөрчсөн байна.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хэрхэн шийдвэртэсэн тухай харну ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

Дарга

Н. ЖАНЦАН

Гишүүд:

Л. БААСАН
С. ЖАНЦАН
Д. ЧИЛХААЖАВ
Ж. БЯМБАЖАВ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН
ХУУЛИЙН ЦЭЦИЙН
ДҮГНЭЛТ

1996 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар
хот

Монгол Улсын Ерөнхий сайд
М. Энхсайхан Монгол Улсын
Үндсэн хуулийн зарим заалтыг
зөрчсөн эсэх тухай маргааныг
хянан хэлэлцсэн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Цэцийн
тарга Г. Совд даргалж гишүүдэд Н. Жанцан, С. Жанцан, Д.
Чилхаажав, Ж. Бямбажав /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй хийв.
Цэцийн дүгнэлтийг Төрийн ордон 1-ийн 251 тоот өрөөнд үйлдэв.

Цэцийн хуралдааны нарийн бичгийн даргаар Б. Цэндээхүүг оролцуулав.

Хуралдаанд өргөдөл гаргагч Г. Ганболд, Д. Дашцэдэн, М. Амарсайхан нар, мөн Ерөнхий сайдын итгэмжлэгдсэн төлөөлөгч Д. Сугар, Р. Ринчинбазар нар оролцов.

1. Иргэн Г. Ганболд Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө: "Монгол Улсын Ерөнхий сайд М. Энхсайхан нь 1996 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр захирамж гаргаж, Нийслэлийн Засаг даргад нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан Жанлавын Наранцацралтыг Нийслэлийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгчээр томилж Цэрэндэмбэрэлийн Баасанжавыг Нийслэлийн Засаг даргын үүрэгт ажлаас чөлөөлсөн шийдвэр гаргасан нь:

"1/ Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 2-т заасан "Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд . . ."

2/ Мөн зүйлийн 3-т " . . . дахин нэр дэвшүүлж томилтол өмнөх Засаг дарга бүрэн эрхээ хэвээр хадгална" гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна" гэжээ.

2. Иргэн Д. Дашцэдэн, М. Амарсайхан нар өргөдөлдөө: "Хурлын төлөөлөгчид ярилцаж тогтсоны дагуу хамгийн олон санал авсан Ж. Наранцацралт, П. Ганбаатар нарын нэрийг саналын хуудсанд бичиж . . . энэ хоёрын аль илүү санал авсныг Нийслэлийн Засаг даргад нэр дэвшүүлж, . . . тогтоол гаргаж, түүнийгээ олонхийн саналаар батлах ёстой байсан. Хуулийн тодорхой заалтыг зөрчсөн ийм процедур нь Нийслэлийн Засаг даргыг хууль зүйн үндэслэлгүй томилох шалтгаан болсныг хянан . . . хэлэлцэж өгнө үү." гэжээ.

Иргэн Г. Ганболд Үндсэн хуулийн цэцэд бичгээр өгсөн тайлбартаа: "Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 2-т заасанчлан нийслэлийн Хурлаас нэр дэвшсэн хүнийг томилох ёстой болохоос Засаг даргаар нэр дэвшээгүй хүнийг үүрэг гүйцэтгэгчээр томилох нь Үндсэн хуулийн зөрчил юм. Засаг даргаа орлох бүрэн эрхтэй Нийслэлийн Засаг даргын орлогч үйл ажиллагаагаа явуулж буй байтал үүрэг гүйцэтгэгч томилох ёсгүй.

Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 2-т Засаг даргыг . . . томилохоос үүрэг гүйцэтгэгч томилохгүй. Эндээс үзэхэд "үүрэг гүйцэтгэгч" нь Засаг даргын бүрэн эрхийг "бүрэн" хэмжээгээр хэрэгжүүлэх субъект болж чадахгүй байна" гэжээ.

М. Амарсайхан бичгээр тайлбар гаргахдаа: "Ж. Наранцацралт, П. Ганбаатар нарын саналын хуудсанд дахин бичиж санал хураалгаж, энэ хоёрын аль илүү олон санал авсан нь Нийслэлийн Засаг даргад нэр дэвшүүлж . . . хуралдаанаас тогтоол гаргаж, түүнийгээ олонхийн

саналаар батлаад Ерөнхий сайдад барих байсан . . . хурал ямар ч тогтоол, шийдвэр гаргаагүй” гэжээ.

Д. Дашцэдэн “Үүрэг гүйцэтгэгчийг тавих болсон нь хууль зүйн үндэслэлгүй бөгөөд . . . Нийслэлийн Засаг даргыг чөлөөлсөн, огцруулсан бол түүний бүрэн эрхийг Засаг даргын орлогч хэрэгжүүлэгч учиртай” хэмээн бичгээр тайлбар гаргажээ.

Ерөнхий сайд М. Энхсайхан Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа: “Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааны үйл ажиллагаа сунжирч, . . . Нийслэлийн Засаг даргад нэр дэвшүүлсэн үйл ажиллагаанд маргаан гарч, зогсонги байдалд орж, хугацаа алдсанаас ажил хохирох нөхцөл байдал үүсч байгааг анхааран үзэж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас нийслэлийн Засаг даргад нэр дэвшин өрсөлдөгчөөс харьцангуй хамгийн олон санал авсан байдлыг үндэслэн Жанлавын Наранцаиралтыг Нийслэлийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгчээр томилсон юм.” гэжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд оролцож Г. Ганболд тайлбар гаргахдаа: “Баасанжав даргыг нэгэнт хавсран гүйцэтгэх боломжгүй албан тушаалд сонгогдсон учир түүнийг Засаг даргын үүрэгт ажлаас чөлөөлсөн нь буруугүй гэж үзэж байна. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал олонхийн саналаар нэр дэвшүүлсэн тогтоол гаргаагүй. Зүй нь хэлэлцэж байгаа асуудлаар хурал тогтоол гаргах ёстой. Тогтоол нь олонхийн саналаар батлагдсан байх ёстой. Ийм тогтоол гараагүй учир нэр дэвшээгүй гэж үзэж байна. Хуульд заасан журмын дагуу нэр дэвшигдэн санал болгоогүй хүнийг үүрэг гүйцэтгэгчээр томилсон Ерөнхий сайдын захирамж Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 2 дахь заалтад харшилж байна гэж үзэж байна” гэжээ.

Цэцийн хуралдаанд иргэн Дашцэдэн гаргасан тайлбартаа: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуралдаанаа дуусаагүй байхад процессыг тасалдуулан Засаг даргын үүрэг гүйцэтгэгчийг томилсон. Учир нь тодорхой хүнийг нэр дэвшүүлж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас төлөөлөгчдийн Хурлаас төлөөлөгчдийн шийдвэр олонхийн саналаар батлагдсан, энэ тухай Ерөнхий сайдад санал болгосон байх ёстой атал тэдгээрийн аль нь ч хийгдээгүй. Үүнээс үзэхэд нэр дэвшүүлэх ажиллагаа хийгдээгүй гэх бүрэн үндэстэй юм.”

Ерөнхий сайдын итгэмжлэгдсэн төлөөлөгч Д. Сугар хуралдаанд оролцон тайлбарлахдаа:

“Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн анхдугаар хуралдаанаас н. Наранцаиралтыг Засаг даргад нэр дэвшүүлсэн гэж үзэж байна. Тогтоол гараагүй нь үнэн. Үүрэг гүйцэтгэгч бол Засаг даргатай адил бүрэн эрхтэй. Ийм учраас адилхан журмаар томилогдох ёстой.

Ерөнхий сайдад н. Наранцаиралтыг Нийслэлийн Засаг даргаар

томилуулах албан ёсны санал ирээгүй.

Гэхдээ иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нэр дэвшсэн хүмүүсээс хамгийн олон санал авсан хүн бол Ж. Наранцацралт мөн тул түүнийг Ерөнхий сайд томилох нь буруугүй" гэжээ.

Хянавал:

1. Цэрэндэмбэрэлийн Баасанжав Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргаар сонгогдсоны учир хавсран ажиллах боломжгүйг харгалзан түүнийг Нийслэлийн Засаг даргын үүрэгт ажлаас чөлөөтсөн Ерөнхий сайд М. Энхсайханы үйл ажиллагаа Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн холбогдох хэсгийг зөрчсөн гэх үндэслэлгүй байна. Түүнчлэн өргөдөл гаргагч Г. Ганболд Ц. Баасанжавыг Нийслэлийн Засаг даргын үүрэгт ажлаас чөлөөтсөн нь Үндсэн хууль зөрчсөн тухай гомдлын шаардлагаа цэцийн хуралдааны явцад татаж авлаа.

2 Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдаан нийслэлийн Засаг даргад нэр дэвшүүлэх асуудлыг эцэслэн шийдвэрлээгүй байна.

3. Монгол Улсын Ерөнхий сайд Нийслэлийн Засаг даргад Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас албан ёсоор нэр дэвшүүлж, санал болгоогүй Ж. Наранцацралтыг нийслэлийн Засаг даргын хууль ёсны орлогч ажил үүргээ гүйцэтгэсээр байхад Нийслэлийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгчээр захирамж гарган томилсон нь Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон дүгнэлт гаргах нь:

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хууль ёсоор нэр дэвшүүлж санал болгоогүй байхад Ж. Наранцацралтыг Нийслэлийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгчээр томилсон Монгол Улсын Ерөнхий сайдын 1996 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 132 дугаар захирамж нь Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн "Засаг даргыг тухайн аймаг, нийслэлийн . . . Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд . . . 4 жилийн хугацаагаар томилно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Энэ дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

Дарга

Гшүүд:

Г. СОВД

Н. ЖАНЦАН

С. ЖАНЦАН

Д. ЧИЛХААЖАВ

Ж. БЯМБАЖАВ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

1996 оны 7 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 244

Улаанбаатар
хот

Эрүүгийн хуулийн 216 дугаар зүйлийг тайлбарлах тухай

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 216 дугаар зүйлийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Эрүүгийн хуулийн “Шүүхийн шийдвэрийг үд биелүүлэх” гэсэн 216 дугаар зүйлийг дор дурдсанаар тайлбарласугай:

1. Эрүүгийн хуулийн 216 дугаар зүйлийн “хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүхийн буюу шүүгчийн тогтоолыг /цаашид шүүхийн шийдвэр гэх/ санаатай биелүүлээгүй” гэдэгт шүүхийн шийдвэрт нэр заагдсан этгээд /шүүгчид, хариуцагч зэрэг/ шүүхийн шийдвэрийн заалтыг хуульд заасан буюу шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба, бусад эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тогтоосон хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлэхээс зайлсхийж цалин, орлого эд хөрөнгөө нуун дарагдуулах, хуурамч гэрээ хэлцлээр бусдад шилжүүлэх, оршин суугаа газраа өөрчилж шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанаас оргон зайлах зэргээр биелүүлэхгүй байхыг ойлгоно. Түүнчлэн шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүргийг /цалингаас суутгал хийх, мөнгө шилжүүлэх гэх мэт/ хуулиар хүлээсэн этгээд энэ үүргээ санаатай биелүүлээгүйг энэ ойлголтод хамааруулна.

2. Мөн зүйлийн “шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд зориуд саад учруулсан” гэдэгт шүүхийн шийдвэр биелүүлэх үүрэг бүхий этгээдээс уул шийдвэрийг биелүүлэхэд нь үүрэг даалгавар өгөх, шийдвэр, үйл ажиллагааг нь зогсоох зэргээр саад учруулсан аж ахуйн нэгж, байгууллагын албан тушаалтан, түүнчлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэгчээс албадан гүйцэтгэх ажиллагаа явуулахад нь цалин орлого, эд хөрөнгийг нуун дарагдуулах, хуурамч баримт бичиг бүрдүүлэх, худал мэдээлэл өгөх, шүүхийн шийдвэр биелүүлэх үүрэг бүхий этгээдийг нуух, оргон зайлсхийхэд нь тус дэмжлэг үзүүлэх зэргээр санаатайгаар саатуулсан албан тушаалтан, иргэдийн үйлдэл, эс үйлдэхүй хамаарна.

3. Мөн зүйлийн шүүхийн шийдвэрийг “санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд зориуд саад учруулсан” гэдгийг Захиргааны

хариуцлагын тухай хуулийг 30 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "шүүхийн шийдвэр, шаардлагыг тогтоосон хугацаанд хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлээгүй буюу биелүүлэхэд саад учруулсан", 30 /4/ дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "Шийдвэр биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн, хуурамч гэрээ хийж, эд хөрөнгөө бусдад шилжүүлсэн, нуусан" гэдгээс ялгахдаа үйлдлийн шинж чанар, арга, төлбөрийн хэмжээ, төлбөрийн чадвар, шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй хугацаа, шалтгаан болон бусад нөхцөл байдлыг харгалзан үзэж байна.

4. Эрүүгийн хуулийн дагуу оногдуулсан зарим төрлийн ялыг эдлэхээс ноцтойгоор зайлсхийж, хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, магадлалыг биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хуулийн "Торгох ялыг хорих ялаар солих тухай санал гаргах" гэсэн 11 дүгээр зүйл, "Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ял биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага" гэсэн 13 дугаар зүйл, "Эд хөрөнгө хураах ялыг биелүүлээгүй этгээдэд хариуцлага хүлээлгэх" гэсэн 15 дугаар зүйлд заасны нэгэн адил Эрүүгийн болон бусад хуульд тусгайлан заасан бол эдгээр зүйлийг хэрэглэж Эрүүгийн хуулийн 216 дугаар зүйлийг хэрэглэхгүй. Түүнчлэн хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн бусад шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тухай бусад хуульд тусгайлан заасан бол Эрүүгийн хуулийн 216 дугаар зүйлийг нэгэн адил хэрэглэхгүй.

5. Эрүүгийн хуулийн 216 дугаар зүйлийг 1996 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөр эхлэн дагаж мөрдөхөөр хуульд заасан тул энэ зүйлийг 1996 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө буюу хойно гарч хүчин төгөлдөр болсон бөгөөд энэ өдөр болон түүнээс хойш биелүүлээгүй байгаа шүүхийн бүх шийдвэрт хамааруулан хэрэглэнэ.

Ерөнхий шүүгч

Д. ДЭМБЭРЭЛЦЭРЭН

Шүүгч

Д. НАМСРАЙЖАВ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

1997 оны 1 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 15

Улаанбаатар
хот

Монгол улсын зохиогчийн эрхийн тухай хуулийн зарим зүйл, хэсгийг тайлбарлах тухай

Монгол Улсын Зохиогчийн эрхийн тухай хуулийг нэг мөр йлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Дээд үүхээс **ТОГТООХ** нь:

Монгол Улсын Зохиогчийн эрхийн тухай хуулийн зарим зүйл, хэсгийг дор дурьдсанаар ойлгон хэрэглэхээр тайлбарласугай:

1. Зохиогчийн эрхийн тухай хуулийн /шаашид "хуулийн гэх/ 3 таар зүйлд заасан "зохиогчийн эрхэд хамаарах бүтээл" гэдэгт зохиогчийн оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон мөөд бодит байдлаар хэлбэржсэн, хуулийн энэ зүйлийн 2 дахь сэгт зааснаас бусад бүтээл туурвилыг хамааруулан ойлгоно.

2. Хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8-д заасан гэрэл ргийн болон түүнтэй төсөөтэй аргаар туурвисан бүтээлийг орлого юх зорилгоор ашиглавал зохиогчийн болон дүрслэгдэж буй хүний вшөөрлийг авч тэдэнтэй буюу тэдний эрх бүхий төлөөлөгчтэй нь рээ хийж гол нөхцлийг харицан тохиролцсон байвал зохино.

3. Зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийг зохиох, туурвихад хоёр юу хэд хэдэн этгээд оролцож тус бүр өөрийн оюуны бүтээлч хувь мрээ уг бүтээлд оруулсан бол Хуулийн 4 дүгээр зүйлийн 2,3 дахь сэгт зааснаар хамтарсан буюу нэгдсэн зохиогчийн эрх тус бүрт нь снэ. Харин материал цуглуулах, зураг, схем зурах зэргээр хиогчид техник ажиллагааны туслалцаа үзүүлсэн этгээдийг мтарсан буюу нэгдсэн зохиогч гэж үзэхгүй.

4. Хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан "албан үүргээ шцэтгэх журмаар бүтээл туурвисан зохиогч" гэдэгт тухайн йгууллагад хөдөлмөрийн болон иргэний бусад гэрээ хэлцэл йгуулан ажиллаж байгаа бөгөөд гэрээнд заасан гүйцэтгэх ажлын ээнд нь тухайн бүтээлийг туурвих үүрэг тусгасан зохиогчийг мааруулан ойлгоно. Харин албан үүргээ гүйцэтгэх журмаар бүтээл /рвисан зохиогч тухайн байгууллагатай гэрээ хэлцэл хийгээгүй т зохиогч нь зохиогчийн амины эрхийг, гэрээнд өөрөөр заагаагүй т албан үүрэг гүйцэтгүүлж санхүүжүүлсэн байгууллага гэрээ, шцэлд заасан болзол, нөхцлийн дагуу /зохиогчийн зөвшөөрлөөр/

зохиогчийн эд хөрөнгийн эрхийг тус тус эдэлнэ.

5. Хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан "хамтын үүсмэл бүтээлийг . . . санхүүжүүлэгч этгээд /продюсор/" гэдэгт тухайн зохиогчтой хөдөлмөрийн буюу бусад гэрээ байгуулан тухайн бүтээлийг туурвих үүрэг гүйцэтгүүлэн санхүүжүүлэх үүрэг хүлээсэн хуулийн этгээд, иргэнийг хамааруулан ойлгоно. Санхүүжүүлэгч нь хамтын үүсмэл бүтээл зохиогчидтой /найруулагч, жүжигчид зэрэг/ гэрээ байгуулж тус бүрт нь олгох хөлсний хэмжээг тогтоосон байвал зохино. Хэрэв дээрх гэрээг байгуулаагүйгээр маргаан гарвал шүүх нэхэмжлэлийг үндэслэн хамтын үүсмэл бүтээл зохиогчийг тогтоох, тэдний хөлсийг эрх бүхий байгууллагаас тогтоосон хэмжээний дотор санхүүжүүлэгчээс гаргуулан олгож байх хэрэгтэй.

6. Хуулийн 16 дугаар зүйлийн 2-т заасан "сургалтад ашиглах" гэдгийг нийтийн хүртээл болсон бүтээлийг аливаа сургууль, дамжаануудын хичээлийн хөтөлбөрийн хүрээнд түүнийг биелүүлэхэд зориулан орлого олох зорилгогүйгээр ашиглахыг ойлгоно. Хэрэв орлого олох зорилгоор бүтээлийг ашиглавал зохиогчийн зөвшөөрлийг авч түүнд төлөх хөлсний хэмжээг тохиролцон гэрээ байгуулсан байх ёстой.

7. Хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Зохиогчийн бүтээлээ ашиглах онцгой эрхийг Монгол Улсын Иргэний хуульд заасан журмын дагуу өвлөнө" гэсэн заалтыг зөвхөн зохиогчийн эд хөрөнгийн эрхийг эрх бүхий этгээд нь хуульд зааснаар буюу гэрээслэлээр өв залгамжлахыг ойлгоно. Зохиогчийн бүтээлээ ашиглах онцгой /эд хөрөнгийн/ эрхийг өв залгамжлах харилцааг бүхэлд нь Иргэний хуулийн YI хэсэгт заасан хэм хэмжээгээр зохицуулна.

8. Зохиогчийн бүтээлээ ашиглах онцгой эрхийг Иргэний хуулийн YI хэсэгт заасан журмаас гадуур өв залгамжилж хууль ёсны өв залгамжлагчийн эрхийг хохироосон бол шүүх эрх бүхий этгээдийн нэхэмжлэлийг үндэслэн хууль ёсны өв залгамжлагчийн эрхийг хамгаалах ба иргэний хуулийн 396 дугаар зүйлийн дагуу уг бүтээлийг ашиглаж олсон орлогыг тогтоон ийнхүү хууль бусаар ашигласнаас олсон орлогыг буруутай этгээдээс гаргуулж улсын орлого болгож байхын хамт өв залгамжлагчид зохих шагналыг олгож байвал зохино.

9. Хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д зааснаар тогтоосон журмын дагуу бүтээлийг бүртгүүлж, бүртгэлийн хураамж төлөөгүй гэсэн үндэслэлээр зохиогчийн эрхтэй холбогдсон нэхэмжлэлийг шүүх хүлээн авахаас татгалзаж болохгүй бөгөөд нэхэмжлэлийн дагуу иргэний хэрэг үүсгэн шалгаж, уг бүтээл нь зохиогчийн эрхэд хамаарах эсэхийг шийдвэрлэж байна.

10. Зохиогчийн эрхтэй холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх явцад тусгай мэдлэг шаарлах асуудал гарвал шүүгчийн захирамж гарган Иргэний хэрэг шүүхэд хянан Шийдвэрлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шинжээч томилж дүгнэлт гаргуулах бөгөөд уул шинжээчийн бүрэлдэхүүнд тухайн салбарын өндөр мэдлэг, мэргэжилтэй хүмүүсийг оруулж, ямар асуудлаар дүгнэлт гаргуулахаа захирамжиндаа тодорхой тусгаж, оюуны өмчийн газрын туслалцааг авч байвал зохино.

Ерөнхий шүүгч

Д. ДЭМБЭРЭЛЦЭРЭН

Танхимын тэргүүн шүүгч

Р. ЖАМЬЯНЧОЙЖИЛ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

1997 оны 1 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар
хот

Байгаль орчныг хамгаалах хуулийн 16 дугаар зүйлийг тайлбарлах тухай

Байгаль орчны яамны хүсэлтийг үндэслэн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийг нэг мөр ойлгож гэрэгжүүлэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Дээд шүүхээс **ТОГТООХ нь:**

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн зарим заалтыг дор дурдсанаар тайлбарласугай:

1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дугаарт заасан "нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг энэ хуульд заасан үндэслэл журмын дагуу тогтоох" гэдгийг Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас мөн хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дүгээрт заасны дагуу төрийн захиргааны төв байгууллага болох Байгаль орчны яамнаас, тухайн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэр дээр тухайн жилд ашиглаж болохоор өвшөөрсөн байгалийн баялгийн дээд хэмжээнд багтаан сум, дүүрэг

бүрийн ашиглаж болох байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг тогтоохыг ойлгоно.

2. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалт, 2 дахь хэсгийн 4 дүгээр заалтын "хяналт тавих" гэдгийг аймаг, нийслэлийн иргэдийн хурал, засаг дарга нь нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар гаргасан төр, засгийн дээд болон төрийн захиргааны төв байгууллага түүнчлэн өөрийн шийдвэрийг биелүүлэх талаар аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хууль тогтоомжийн дагуу шийдвэрийн биелэлтийг хангуулах, сонсгол мэдээллийг авч хэлэлцэх, хянан шалгах, гэм буруутай этгээдэд зохих хариуцлага хүлээлгэх гэх зэргээр хяналт тавихыг ойлгоно.

Ерөнхий шүүгч

Д.ДЭМБЭРЭЛЦЭРЭН

Шүүгч

Ж. ДАНЦОРЖ

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч	Л. Цог
Харууцлагатай нарийн бичгийн дарга	Б. Ганбат
Гишүүд:	Б. Бадамханд Ч. Дашням Б. Цэндлоо Б. Чимид Б. Энэбин
Техник редактор	С. Итгэлт
Уншиж хянасан	Сав. Жаргалсайхан Б. Янжинтхам

Үйлдвэрт шилжүүлсэн 1997 оны 4-р сарын 5-нд
Өрөлтөд 1997 оны 4-р сарын 8-нд. Хэвлэлтэд
1997 оны 4-р сарын 28-нд. Хэвлэлийн хуудас 6,25.
Хэвтэсэн тоо 4407

Манай хаяг: Улаанбаатар-12
Төрийн ордон. Утас 322838

Төр, Засгийн Үйлдвэлгээ Аж Ахуйг
Эрхлэх Газрын харьяа
Хэвлэх үйлдвэр

